

ДЭЛГЭРЭНГҮЙ ТАНИЛЦУУЛГА

Уур амьсгалын өөрчлөлтийн тухай
хуулийн төслийн талаар

Нэг. Монгол Улсын уур амьсгалын өөрчлөлт, хүлэмжийн хийн ялгарлын өнөөгийн нөхцөл байдал

Монгол улс 2020 онд нийт 43,081.62 мян. т CO₂-экв. (газар ашиглалт, газрын ашиглалтын өөрчлөлт ба ойн салбарын тооцоогүй) ялгаруулсны 51.97% нь хөдөө аж ахуйн салбар, 44.78% нь эрчим хүч, 2.66% нь аж үйлдвэр, 0.58% нь хог хаягдлын салбар ялгарсан байна. Хүлэмжийн хийн бүтцээр авч үзвэл 42.40%-ийг нүүрсхүчлийн давхар исэл буюу нүүрсхүчлийн хий (CO₂), 33.82%-ийг метан хий (CH₄), 22.46%-ийг азотлог исэл (N₂O), 1.33%-ийг гидрофторт нүүрстөрөгч (HFCs) тус тус эзэлж байна.¹

Монгол Улс сүүлийн 80 гаруй жилийн хугацаанд агаарын температурын жилийн дундаж хэм 2.46°C-ээр нэмэгдсэн нь дэлхийн дундаж өөрчлөлттэй харьцуулахад өндөр үзүүлэлт юм. Сүүлийн 45 жилд хүйтэн өдрийн тоо дунджаар 15 хоногоор буурч, халуун өдрийн тоо 24 хоногоор нэмэгджээ. Дулааны улиралд орох хур тунадас буурч ууршилт ихэссэний улмаас хуурайших хандлагатай байна.²

Монгол Улсын далайд гарцгүй газар зүйн байршил, агаарын температур нь -8°C-ээс +6°C-ийн (зуны дундаж температур 10°C-26°C, өвлийн дундаж температур -15°C-аас -30°C) хооронд хэлбэлздэг, жилийн нийт хур тунадас нь говийн бүсэд 50 мм, нутгийн хойд уулархаг нутагт 400 мм ордог нь монголыг уур амьсгалын өөрчлөлтийн нөхцөлд илүү өртөмтгий, эмзэг байдалд оруулдаг байна.

Уур амьсгалын өөрчлөлтийн талаар 2009 болон 2014 онуудад хийсэн үнэлгээгээр³ монголын экосистем ихээхэн эмзэг, эдийн засаг нь мал аж ахуйгаас хамааралтай, хур борооны хэмжээнээс шууд хамааралтай газар тариалантай, хүн ам нь хурдацтай нэмэгдэж байгаа, уламжлалт нүүдлийн ахуйтай боловч хотжилтын хандлага давамгайлж байгаа зэрэг олон хүчин зүйл нь Монгол Улсыг уур амьсгалын өөрчлөлтөд маш эмзэг, өртөмтгий болгож байна гэсэн дүгнэлт хийсэн байна.

Уур амьсгалын өөрчлөлтийн сөрөг нөлөөлөл нь:

- (1) Усны хомсдол – өндөр уулын цас, мөсөн голууд хайлж, гадаргын усны нөөц багассанаар,
- (2) Цөлжилт – хөрсний болон газар, бэлчээрийн доройтол нэмэгдсэнээр
- (3) Ойн экосистемийн доройтол – хортон шавж, түймрийн аюул ихэссэнээр
- (4) Ядуурал, хүнсний аюулгүй байдал нь байгалийн нөөц баялаг, хөдөө аж ахуй, газар тариалангийн нөөц, хомсдол үүссэнээр,
- (5) Хүний эрүүл мэндийн хохирол – экологийн тэнцвэрт байдлын алдагдал, байгаль орчны бохирдсоноос,
- (6) Биологийн олон янз байдлын доройтол нь дээрх сөрөг нөлөөллийн улмаас зарим төрөл зүйлийн ургамал, зэрлэг ан амьтан устаж, тоо толгой цөөрснөөр,

¹ Монгол Улсын Хүлэмжийн хийн ялгарал, шингээлтийн хоёр жил тутмын хоёрдугаар тайлан-илтгэл (BUR2) - 2023,

² Монгол Улсын Уур амьсгалын өөрчлөлтийн Үндэсний дөрөвдүгээр тайлан-илтгэл 2024,

³ Монгол Улсын уур амьсгалын өөрчлөлтийн үнэлгээний тайлан 2009, 2014 он,

(7) Үер, ган зуд, газар хөдлөлт зэрэг байгалийн гамшигт үзэгдлийн улмаас нийгэм, эдийн засгийн ихээхэн хэмжээний гарз хохирол, хор уршгийг үзүүлж байгаагаар тус тус илэрч байна.

Тухайлбал, судлаачдын тогтоосноор 1971 оны байдлаар нийт газар нутгийн 63%-д олон жилийн цэвдэг тархсан байсан бол 2016 онд 29.3% болсон байна. 2000-2015 оны хооронд нийт нуур цөөрмийн 21%, гол мөрний 12%, горхи булгийн 15% нь хатаж ширгэсэн гэсэн судалгаа байдаг. Гэхдээ мөсөн гол%, цэвдгийн хайлалтын улмаас зарим газар, булаг шанд эргэн сэргэх, шинээр гарах тохиолдол бас ажиглагдаж байна. Манай улсад хүчтэй салхи, цасан шуурга, аадар бороо, аянга цахилгаан, үер, ой хээрийн түймэр, ган, зуд зэрэг цаг агаарын гаралтай аюулт, гамшигт үзэгдэл жилд дунджаар 54 удаа тохиодог бөгөөд харин тэдгээрийн давтамж сүүийн 20 жилд 2 дахин нэмэгджээ.⁴

Уур амьсгалын өөрчлөлтийн сөрөг нөлөөлөл, үр дагарыг байгалийн нөөц, экосистемийн гол бүрэлдэхүүн болон нийгэм-эдийн засгийн гол салбаруудаар хураангуйлан тоймлосныг Уур амьсгалын өөрчлөлтийн үнэлгээний 2014 оны тайланд тусгажээ⁵. Үүнд өнөөгийн уур амьсгалын элементүүдийн өөрчлөлт, байгаль, нийгэм-эдийн засгийн салбарт гарсан гол нөлөөлөл, ирээдүйн нөлөөлөл, эмзэг байдал, эрсдэлийн үнэлгээний гол үр дүн, шаардлагатай авч хэрэгжүүлэх, арга хэмжээ, үйл ажиллагаа зэргийн оруулсан байна.

Монгол улсын уур амьсгалын нөлөөлөл, эмзэг байдал, эрсдэлийн тоо баримт, мэдээллүүдээс үзэхэд Монгол орны нутаг дэвсгэрт бүх улирлын агаарын температур цаашид тогтвортой нэмэгдэж дулаарах, хур тунадас өвөл нэмэгдэх хэдий ч, зуны улиралд нэмэгдэхээргүй төсөөлөгдөж байгаа явдал нь ерөнхийдөө уур амьсгалын ган, хуурайшлыг улам эрчимжүүлж, манай орны байгаль, нийгэм-эдийн засгийн салбаруудад шууд ба шууд бус байдлаар нөлөөлөхөөр байна.

Хоёр. Хуулийн төсөл боловсруулах үндэслэл

Монгол Улс Уур амьсгалын өөрчлөлтийн тухай НҮБ-ын суурь конвенцыг 1993 онд, конвенцын Парисын хэлэлцээрийг 2016 онд тус тус Улсын Их Хурлаар соёрхон баталж, уур амьсгалын өөрчлөлтийг сааруулах, дасан зохицох чиглэлээр олон улсын өмнө үүрэг, амлалт хүлээсэн.

Парисын хэлэлцээрийн 4.2 дахь хэсэгт Талууд Үндэсний тодорхойлсон хувь нэмэр (ҮТХН)-ээ боловсруулж, мэдээлж, хэрэгжүүлэх үүргийг, 4.3 дахь хэсэгт ҮТХН-ээ шинэчлэхдээ өмнөхөөсөө ахицтай зорилт дэвшүүлэх шаардлагыг тус тус тодорхойлсон байдаг. Мөн 4.9 дэх хэсэгт ҮТХН-ээ таван жил тутам шинэчлэх, 4.13 дахь хэсэгт хэрэгжилтийн хэмжилт, тайлагнал, баталгаажуулалтын тогтолцоонд ил тод, үнэн зөв байдлыг хангах шаардлагыг тусгасан бөгөөд Парисын хэлэлцээрийн 13 дугаар зүйлээр Ил тод байдлын сайжруулсан тогтолцоо (Enhanced Transparency Framework)-г хэрэгжүүлэх үүргийг Талуудад үүрэгжүүлсэн.

Түүнчлэн Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлого “Алсын хараа-2050”-д нүүрстөрөгч багатай, хүртээмжтэй ногоон эдийн засгийг хөгжүүлэх, уур амьсгалын өөрчлөлтийг сааруулах, дасан зохицох, нүүрстөрөгчийн шингээлтийг нэмэгдүүлэх зорилтыг үе шаттайгаар хэрэгжүүлэхээр тусгасан. Мөн Монгол Улсын Засгийн газрын 2024-2028 оны үйл ажиллагааны хөтөлбөрт хүлэмжийн хийн тайлагналын тогтолцоог бэхжүүлэх, нүүрстөрөгчийн кредит, карбон зах зээлийн эрх зүйн орчныг бүрдүүлэх, ногоон санхүүжилт, хөрөнгө оруулалтыг нэмэгдүүлэх чиглэлээр салбар дундын зохицуулалтыг сайжруулах зорилтыг тусгасан байдаг.

⁴ Үндэсний тодорхойлсон хувь нэмэр 3.0 2025 он,

⁵ Монгол Улсын уур амьсгалын өөрчлөлтийн үнэлгээний тайлан 2014,

Нөгөө талаас Монгол Улс нүүрстөрөгчийн өндөр агууламжтай эдийн засгийн бүтэцтэй хэвээр байгаа бөгөөд үндэсний эрчим хүчний системийн нийлүүлэлтийн 90 орчим хувь нь нүүрсээр ажилладаг дулааны цахилгаан станцаас бүрдэж, мал аж ахуйн салбар нийт хүлэмжийн хийн ялгарлын томоохон эх үүсвэр болж байна. Үүнээс гадна уур амьсгалын өөрчлөлтийн нөлөөлөл, эрсдэл эрчимтэй нэмэгдэж, ган, зуд, цөлжилт, усны нөөцийн хомсдол, бэлчээрийн доройтол, гамшигт үзэгдлийн давтамж, эрчим өсөх хандлагатай байна. Иймд хүлэмжийн хийн ялгарлыг бууруулах, сэргээгдэх эрчим хүч, ногоон хөгжил, тогтвортой үйлдвэрлэл, хэрэглээг дэмжихийн зэрэгцээ уур амьсгалын өөрчлөлтийн байгаль орчин, нийгэм, эдийн засаг, хүний эрүүл мэндэд үзүүлж буй сөрөг нөлөөллийг бууруулах шаардлага үүсээд байна.

Гэвч уур амьсгалын өөрчлөлттэй холбоотой харилцааг өнөөг хүртэл хөгжлийн бодлогын баримт бичгийн хүрээнд хэсэгчлэн зохицуулж ирсэн бөгөөд уур амьсгалын өөрчлөлтийн засаглал, салбар дундын зохицуулалт, хүлэмжийн хийн хэмжилт, тайлагнал, баталгаажуулалт, ногоон санхүүжилт, карбон зах зээлийн нэгдсэн эрх зүйн орчин хангалтгүй байна. Цаашид ҮТХН-ийг таван жил тутам шинэчилж, хэрэгжилтийг тогтмол үнэлэх, тайлагнах, олон улсын гэрээгээр хүлээсэн үүргийн хэрэгжилтийг хангах, салбар дундын зохицуулалт, санхүүжилт, хэмжилт-тайлагнал-баталгаажуулалтын тогтолцоог бэхжүүлэх эрх зүйн суурь шаардлага үүсээд байна.

Иймд уур амьсгалын өөрчлөлтийг сааруулах, дасан зохицох, даван туулах бодлого, арга хэмжээг хэрэгжүүлэх, ҮТХН-ийн зорилт, арга хэмжээг урт хугацаанд тогтвортой хэрэгжүүлэх, ногоон санхүүжилт, карбон зах зээлийг хөгжүүлэх, уур амьсгалын өөрчлөлтийн сөрөг нөлөөллийг бууруулах нэгдсэн эрх зүйн орчныг бүрдүүлэх зорилгоор “Уур амьсгалын өөрчлөлтийн тухай” хуулийн төслийг боловсруулсан болно.

Гурав. Олон улс дахь уур амьсгалын өөрчлөлтийн тухай хууль, эрхзүйн зохицуулалт

Одоогоор нийтдээ 50 гаруй улс орон уур амьсгалын өөрчлөлтийн тухай суурь хуультайгаас 30⁶ нь Европын улсууд бөгөөд эдгээр улсууд нь хоорондоо улс төр, эдийн засаг, нийгмийн хөгжил ойролцоо, соёл шашин нь адилхан. Энэ нөхцөлийг харгалзан судалгаанд хамрагдсан орнуудыг Европын орнууд болон бусад орнууд гэсэн ангиллаар хувааж судаллаа.

1. Европын орнууд

Европын орнуудын уур амьсгалын өөрчлөлтийн хуулиуд нь параах нийтлэг шинжтэй. Нарийвчилсан судалгааг, Их Британи, Австри, Герман улсуудын уур амьсгалын хуулийн хүрээнд хийсэн.

- Хуулийн зорилтдоо эсвэл эрх барих дээд байгууллагын үүрэгт НҮБ-ын уур амьсгалын өөрчлөлтийн тухай конвенцын суур зарчим, Парисын хэлэлцээрийг хэрэгжүүлэх явдлыг ямар нэгэн хэлбэрээр оруулдаг. Энэ нь бусад буурай хөгжилтэй орнуудтай харьцуулахад уур амьсгалын өөрчлөлтийн асуудлыг шийдвэрлэх явцад дагалдан гарах бусад асуудлууд (ажилгүйдэл, ядуурал, дэд бүтцийн хүрэлцээгүй байдал, нийгмийн салбарын хамнамж муу гэх мэт) харьцангуй бага байдагтай холбоотой.

- Зарим орнууд хэлэлцээрээр хүлээсэн хүлэмжийн хийн ялгарлыг бууруулах ҮТХН-ийн амлалтаа хугацаатай хуулийн зорилт болгон оруулсан. Уур амьсгалын өөрчлөлтийн хууль нь давхар өөр асуудлыг шийдвэрлэх, зохицуулах шаардлагагүй учраас шууд амлалт руугаа чиглэдэг.

- Хуулиуд нь уур амьсгалын өөрчлөлтийн хууль гаргахтай холбоотойгоор шинэ нүсэр бүтэц бий болгоогүй. Өмнө нь уур амьсгалын өөрчлөлтийн чиглэлээр тодорхой үйл

⁶ Grantham Research Institute (LSE)-ийн Climate Change Laws of the World мэдээллийн сан

ажиллагааг бусад хуулиудын хүрээнд (эрчим хүч, хог хаягдал, байгаль орчин) явуулж байсан учраас байгуулсан алба, нэгж, бүтцээрээ дамжуулан шинэ хуулийн хэрэгжилтийг хангах бололцоо ихтэй.

- Хуулийг хэрэгжүүлэх бодлогын баримт бичгийн оронд ажлын тайлан гаргадаг. Амлалтаа зорилт болгож тодорхой хэмжих нэгж, хугацаатай хуульчилсан орнуудын хувьд хууль нь бодлогын баримт бичгийн үүргийг давхар гүйцэтгэдэг байх талтай.

Бусад улсуудын хууль

Бусад орнуудын харьцуулсан судалгаанд Пакистан, Балба, Кени, Филиппин зэрэг хөгжиж буй орнуудын уур амьсгалын өөрчлөлтийн суурь хууль, институцийн тогтолцоо, санхүүжилт, хэрэгжилтийн зохицуулалтыг хамруулан судалсан. Мөн Йордан Улсыг Ойрх Дорнодын бүс нутагт уур амьсгалын өөрчлөлтийн үндэсний бодлогыг анхлан боловсруулж хэрэгжүүлсэн, тусгай суурь хуульгүй боловч бодлогын баримт бичиг, салбар дундын зохицуулалтаар дамжуулан уур амьсгалын өөрчлөлтийн асуудлыг зохицуулж буй жишиг орон гэдгээр нь судалгаанд хамруулсан болно.

- Хуулийн зорилтдоо Парисын хэлэлцээрийг шууд нэрлэн хэрэгжүүлэх тухай тусгахаас илүүтэй Уур амьсгалын өөрчлөлтийн тухай НҮБ-ын суурь конвенц болон олон улсын гэрээ, хэлэлцээрээр хүлээсэн үүргийг хэрэгжүүлэх талаар ерөнхий байдлаар томъёолсон байна. Энэ нь уур амьсгалын өөрчлөлтийн асуудал нь зөвхөн хүлэмжийн хийн ялгарлыг бууруулах хүрээнд хязгаарлагдахгүй, тухайн улсын нийгэм, эдийн засаг, ажил эрхлэлт, ядуурал, орон нутгийн хөгжил, дэд бүтцийн хүртээмж, хүнсний аюулгүй байдал, эрчим хүчний хүртээмж, үндэсний өв соёл, уламжлалт амьдралын хэв маяг зэрэг өргөн хүрээний хөгжлийн асуудалтай нягт холбоотой байдагтай холбоотой байна.

- Хэлэлцээрээр хүлээсэн хүлэмжийн хийн ялгарлыг бууруулах ҮТХН-ийн амлалтаа хуулийн дагуу парламент эсвэл Засгийн газраар баталгаажуулсан бодлогын баримт бичигт оруулдаг. Амлалтаа хуульчлах нь олон улсын хэмжээнд заавал биелүүлэх үүрэг болох эрсдэлтэй, нөгөө талаар тухайн улсуудын улс төрийн нөхцөл байдал, улсынх нь хөгжлийн стратеги нөлөөлөх талтай.

- Уур амьсгалын өөрчлөлтийн тухай суурь хууль баталсантай холбоотойгоор ихэнх улс орон эрх барих дээд байгууллага болох Үндэсний хороо, комисс, зөвлөл зэрэг салбар дундын зохицуулалтын бүтцийг байгуулж, түүний дэргэд хэрэгжилтийг хангах мэргэжлийн болон техникийн ажлын албыг шинээр байгуулсан байна. Энэ нь уур амьсгалын өөрчлөлтийн асуудал нь олон салбар, байгууллагын оролцоо шаарддаг тул бодлого, төлөвлөлт, тайлагнал, санхүүжилт, олон улсын хамтын ажиллагааны хэрэгжилтийг нэгдсэн зохицуулалтаар хангах шаардлагатай холбоотой байна. Мөн хөгжиж буй орнуудын хувьд өмнө нь уур амьсгалын өөрчлөлтийн чиглэлээр дагнасан институц, мэргэжлийн бүтэц хангалтгүй байсан тул хууль хэрэгжүүлэх чадавх, салбар дундын уялдаа холбоог хангах зорилгоор үндэсний зохицуулагч байгууллага, техникийн болон мэргэжлийн зөвлөлийг шинээр байгуулах хэрэгцээ нийтлэг үүссэн байна.

- Судалгаанд хамрагдсан хөгжиж буй орнуудын нийтлэг зохицуулалтын нэг нь уур амьсгалын өөрчлөлтийн тусгай сан, санхүүжилтийн механизмыг хуулиар байгуулах асуудал байна. Учир нь эдгээр улс оронд өмнө нь уур амьсгалын өөрчлөлтийн чиглэлээр тогтвортой санхүүжилтийн тогтолцоо бүрдээгүй, төсөв, хөрөнгө оруулалтыг нэгдсэн байдлаар төлөвлөж байгаагүйгээс уур амьсгалын бодлого, арга хэмжээг хэрэгжүүлэхэд санхүүгийн хүндрэл үүсдэг байна. Иймээс уур амьсгалын өөрчлөлтийн тухай хуулиар үндэсний сан, зориулалтын санхүүжилтийн механизм, олон улсын уур амьсгалын санхүүжилт татах, хувийн хэвшлийн хөрөнгө оруулалтыг дэмжих эрх зүйн үндсийг бүрдүүлэх хандлага нийтлэг байна.

- Хуулийн хамрах хүрээ нь өргөн. Учир нь хүчин төгөлдөр мөрдөгдөж буй салбарын хууль тогтоомжууд нь уур амьсгалын өөрчлөлтийн асуудлыг цогцоор нь зохицуулаагүй,

эсхүл хүлэмжийн хийн ялгарал, дасан зохицох бодлого, санхүүжилт, тайлагнал зэрэг асуудлыг хангалттай тусгаагүй байдаг. Иймээс шинэ суурь хуулиар эрчим хүч, хөдөө аж ахуй, ой, ус, газар ашиглалт, тээвэр, барилга, хог хаягдал, эрүүл мэнд, гамшгийн эрсдэл, санхүүжилт, мэдээллийн сан, тайлагнал зэрэг олон салбарын уялдаа холбоог нэгтгэн зохицуулах шаардлага үүсдэг байна.

Уур амьсгалын өөрчлөлтийн хуультай холбоотой ирээдүйн чиг хандлага:

Уур амьсгалын өөрчлөлттэй холбоотой асуудлуудыг улс орнууд суурь хуулиар эсвэл бодлогын баримт бичгийн хүрээнд эсвэл эдгээрийн хослон байдлаар зохицуулах гэсэн нийтлэг 3 хэлбэр байна. Үүнээс бодлогын баримт бичгээр зохицуулах хэлбэр нь цаашид халагдах төлөвтэй. Уур амьсгалын өөрчлөлтийн суурь хууль гарснаар:

- (1) тухайн улсын олон улсын хэмжээнд авсан амлалтыг дотооддоо хуульчилдаг;
- (2) хуульчилснаар зорилт тодорхой болж биелэх боломж, магадлал ихэсдэг;
- (3) хууль баталснаар үндэсний хэмжээний эрх мэдэл бүхий байгууллага бий болж хуулийн хэрэгжилт сайжирна;
- (4) тухайлсан төсөв бүхий зориулалтын сан байгуулагдаж санхүүгийн эх үүсвэр нь шийдэгддэг;
- (5) уур амьсгалын асуудлыг дотоодын улс төрийн нөлөөллөөс хамгаалдаг гэсэн нийтлэг дүгнэлт хийж байна.

Цаашид дэлхийн уур амьсгалын өөрчлөлтийн сөрөг нөлөөлөл эрчимжихийн хэрээр улс орнуудын энэ чиглэлд авч хэрэгжүүлж буй бодлого, арга хэмжээний үр дүн, хэрэгжилтийн бодит байдал олон улсын түвшинд улам чухал ач холбогдолтой болж байна. Энэ хүрээнд улс орнуудын хэрэгжүүлж буй гол арга хэмжээний нэг нь уур амьсгалын өөрчлөлтийн суурь эрх зүйн орчныг бүрдүүлж, холбогдох хуулийг батлан хэрэгжүүлэх явдал болж байна.

Одоогоор олон улсын гэрээ, хэлэлцээрийн хүрээнд улс орон бүр уур амьсгалын өөрчлөлтийн тухай бие даасан хууль заавал батлах үүрэг хүлээгээгүй боловч Парисын хэлэлцээрийн хэрэгжилт, Үндэсний тодорхойлсон хувь нэмэр (ҮТХН)-ийн зорилт, хүлэмжийн хийн тайлагнал, ногоон санхүүжилт, карбон зах зээлийн зохицуулалтыг хэрэгжүүлэхийн тулд суурь хуультай байх олон улсын чиг хандлага эрчимтэй нэмэгдэж байна.

Ийм суурь хууль нь тухайн улсын уур амьсгалын өөрчлөлтийн бодлого, засаглал, салбар дундын зохицуулалт, санхүүжилт, хариуцлагын тогтолцоог нэгтгэн зохицуулах үндсэн хэрэгсэл болдог бөгөөд цаашид уур амьсгалын өөрчлөлтийн асуудал нь олон улсын хамтын ажиллагаа, худалдаа, хөрөнгө оруулалт, хөгжлийн бодлоготой улам нягт уялдах тул энэ чиглэлийн эрх зүйн орчин нь улс орнуудын олон улсын өмнө хүлээсэн үүргийн хэрэгжилтийг үнэлэх чухал шалгуурын нэг болох хандлагатай байна.

Иймд Монгол Улс уур амьсгалын өөрчлөлт, хүлэмжийн хийн ялгарлын өнөөгийн болон ирээдүйн стратегийн үнэлгээг холбогдох салбаруудаар гаргах, түүний үр дүнг үндэслэн хүлэмжийн хийг бууруулах, уур амьсгалын өөрчлөлтөд дасан зохицох зорилт, арга хэмжээ, үйл ажиллагааг хууль, бодлого, стратеги, төлөвлөлттэй уялдуулж хэрэгжүүлэх хууль, эрх зүйн тодорхой орчныг бий болгох шаардлагатай байна.

Хууль санаачлагчийн зүгээс Монгол Улсын хувьд өнөөгийн нөхцөл, байдалтай уялдуулан Уур амьсгалын өөрчлөлтийн асуудлыг шинэ шатанд гаргаж, хууль, эрх зүйн тодорхой орчныг бүрдүүлэх зорилгын хүрээнд Уур амьсгалын өөрчлөлтийн асуудлуудыг өөрийн орны онцлог, дэлхийн нийтийн чиг хандлагад нийцүүлэн тодорхойлж, олон улсын шинэлэг зохицуулалтыг нэвтрүүлэх, уур амьсгалын өөрчлөлтийг сааруулах, түүнд дасан

зохицох чадварыг бүрдүүлэх, хүлэмжийн хийг бууруулах цогц бодлогыг хэрэгжүүлэхэд хууль эрх зүйн зөв, тогтвортой орчныг бий болгох зайлшгүй шаардлагатай гэж үзсэн бөгөөд Уур амьсгалын өөрчлөлтийн тухай хуулийн зохицуулалтын хувилбарыг сонгосон болно.

Холбогдох судалгааны хүрээнд уур амьсгалын өөрчлөлтийн асуудлаар одоогийн тодорхойгүй байгаа эрх зүйн зохицуулалтуудыг тодорхой болгох, нэр томьёоны зөрүүг жигдлэх, олон улсын жишигт нийцсэн, практик шаардлагад тулгуурласан хууль, эрх зүйн орчныг бүрдүүлэх буюу Уур амьсгалын өөрчлөлтийн тухай хуулийн төсөл боловсруулах нь зүйтэй гэж үзсэн байна. Тиймээс голлох зохицуулалтын асуудлыг судалгааны явцад гаргаж дараах асуудлуудыг хуульд тодорхойлох нь зөв гэж үзлээ. Үүнд:

(1) Уур амьсгалын өөрчлөлтийг сааруулах, дасан зохицох, хүлэмжийн хийн ялгарлыг бууруулах, шингээлтийг нэмэгдүүлэх чиглэлээр Монгол Улсын урт, дунд хугацааны зорилт, бодлогын үндсийг тодорхойлох;

(2) Уур амьсгалын өөрчлөлтийн бодлого, арга хэмжээг “Алсын хараа-2050”, дунд хугацааны хөгжлийн бодлого болон Үндэсний тодорхойлсон хувь нэмэр (ҮТХН)-ийн зорилттой уялдуулан хэрэгжүүлэх төлөвлөлт, зохицуулалтын тогтолцоог хуульчлах;

(3) Уур амьсгалын өөрчлөлтийн асуудлыг хариуцах төрийн байгууллагуудын бүтэц, зохион байгуулалт, бүрэн эрх, чиг үүрэг, хариуцлагыг тодорхойлох;

(4) Аж ахуйн нэгж, байгууллага, иргэн болон бусад оролцогч талуудын эрх, үүрэг хариуцлагын тогтолцоог бүрдүүлэх;

(5) Аймаг, нийслэл, сум, дүүргийн түвшинд уур амьсгалын өөрчлөлтийн бодлого, арга хэмжээг хэрэгжүүлэхтэй холбоотой нутгийн захиргааны байгууллагын чиг үүргийг тодорхойлох;

(6) Уур амьсгалын өөрчлөлтийн асуудлаарх үндэсний зохицуулалтын тогтолцоог боловсронгуй болгож, үндэсний зохицуулагч байгууллага, техникийн болон мэргэжлийн зөвлөлийн үйл ажиллагааны эрх зүйн үндсийг тодорхойлох, төрийн байгууллагуудын салбар дундын уялдаа, хамтын ажиллагааг хангах;

(7) Хүлэмжийн хийн үндэсний тооллого, ҮТХН-ийн хэрэгжилт, хэмжилт-тайлагнал-баталгаажуулалтын (MRV) тогтолцоо, тайлагнал, хяналт-шинжилгээ, үнэлгээний зохицуулалтыг бүрдүүлэх;

(8) Уур амьсгалын санхүүжилт, ногоон санхүүжилт, карбон зах зээл болон холбогдох санхүүгийн зохицуулалтын эрх зүйн үндсийг бий болгох;

(9) Уур амьсгалын өөрчлөлтийн мэдээллийн нэгдсэн сан – Үндэсний платформ, мэдээллийн ил тод байдал, мэдээлэл солилцоо болон олон нийтийн оролцоог хангах тогтолцоог бүрдүүлэх.

Иймд дээр дүрдсан нөхцөл байдал, судалгааны дүн, Монгол Улсын эрх зүйн үндсэн зарчим, олон улсын сайн түршлага, зарчмуудтай нийцүүлэн Уур амьсгалын өөрчлөлтийн тухай хуулийн төслийг 9 бүлэгтэй хуулийн төслийг боловсрууллаа.

Дөрөв. Хуулиар зохицуулахаар тусгасан харилцааны агуулга, зохицуулалтыг тайлбар

Хуулийн төсөл нь дараах бүлгээс бүрдэх ба бүлэг тус бүрийн зохицуулах харилцааны агуулга, зохицуулалтыг тайлбарлав. Үүнд:

Нэгдүгээр бүлэгт хуулийн зорилго, уур амьсгалын өөрчлөлтийн тухай хууль тогтоомж, хуулийн үйлчлэх хүрээ, уур амьсгалын өөрчлөлтийн үйл ажиллагаанд баримтлах 10 зарчим болон хуулиар хэрэглэсэн 40 нэр томьёоны тодорхойлолтыг тусгасан.

Энэ бүлгээр хуулийн зорилго, хамрах хүрээ, нэр томьёо, үндсэн зарчим болон хуулийн хэрэглэх хүрээг тодорхойлсон. “Уур амьсгалын өөрчлөлтийн тухай” хуулийн төсөлд хэрэглэсэн нэр томьёоны тодорхойлолт, ухагдахууны үүслийг тайлбарлахад Хууль тогтоомжийн тухай хуулийн 33.5-д заасны дагуу Уур амьсгалын өөрчлөлтийн тухай НҮБ-ын суурь конвенц, Парисын хэлэлцээрт заасан нэр томьёо, тодорхойлолт, хэм хэмжээг баримталсан болно. Мөн уур амьсгалын өөрчлөлтийн бодлого, арга хэмжээг шинжлэх ухаанд суурилсан, ил тод, тэгш хүртээмжтэй, салбар дундын уялдаатай, хүний эрхийг дээдэлсэн, ирээдүй хойч үеийн ашиг сонирхлыг хамгаалсан зарчмаар хэрэгжүүлэх эрх зүйн үндсийг тогтоосон. Түүнчлэн “Үндэсний тодорхойлсон хувь нэмэр”, “карбон кредит”, “ногоон санхүүжилт”, “тэгш хүртээмжтэй шилжилт” зэрэг шинэ ойлголтыг хууль зүйн хувьд тодорхойлж, нэгдсэн хэрэглээг бий болгож байгаа ач холбогдолтой.

Хоёрдугаар бүлэгт уур амьсгалын өөрчлөлтийн асуудлаарх төрийн байгууллагууд болох Монгол Улсын Их Хурал, Засгийн газар, холбогдох төрийн захиргааны төв байгууллагын чиг үүрэг, төрийн захиргааны байгууллага, нутгийн захиргааны байгууллагын болон хүлэмжийн хийн бүртгэл хариуцсан байгууллагын эрх, үүргийг тусгасан.

Энэ бүлгээр уур амьсгалын өөрчлөлтийн асуудлаарх төрийн байгууллагуудын чиг үүрэг, эрх хэмжээ, салбар дундын зохицуулалтын тогтолцоог тодорхойлсон. Уур амьсгалын өөрчлөлтийн асуудал нь эрчим хүч, хөдөө аж ахуй, тээвэр, барилга, санхүү, байгаль орчин зэрэг олон салбарыг хамардаг тул төрийн байгууллагуудын хамтын ажиллагаа, уялдаа холбоог хангах механизмыг тусгасан. Мөн үндэсний зохицуулагч байгууллага, техникийн болон мэргэжлийн зөвлөлийн үйл ажиллагааны эрх зүйн үндсийг тодорхойлж, бодлого боловсруулах, хэрэгжилтийг уялдуулах, шинжлэх ухаан, техникийн зөвлөмжөөр хангах тогтолцоог бүрдүүлсэн. Түүнчлэн орон нутгийн байгууллагуудын оролцоо, чиг үүргийг тодорхойлж, уур амьсгалын өөрчлөлтийн бодлогыг үндэсний болон орон нутгийн түвшинд уялдуулан хэрэгжүүлэх нөхцөлийг бүрдүүлсэн.

Гуравдугаар бүлэгт уур амьсгалын өөрчлөлтийн нөлөөлөл, эмзэг байдал, эрсдэлийн үнэлгээ, хүлэмжийн хийн үндэсний тооллого, уур амьсгалын өөрчлөлтийн судалгаа, шинжилгээ, мэдээллийн суурь тогтолцоотой холбогдсон харилцааг тусгасан.

Энэ бүлгээр уур амьсгалын өөрчлөлтийн нөлөөлөл, эмзэг байдал, эрсдэлийн үнэлгээ хийх, хүлэмжийн хийн үндэсний тооллого боловсруулах, ялгарал, шингээлтийн хэтийн төлөв, төсөөлөл гаргах, хэмжилт-тайлагнал-баталгаажуулалтын (MRV) тогтолцоог бүрдүүлэх, олон улсын тайлагналын үндэс суурийг хангахтай холбоотой харилцааг зохицуулсан.

Тодруулбал, уур амьсгалын өөрчлөлтийн өнөөгийн төлөв байдал, ирээдүйн чиг хандлага, нөлөөллийн үнэлгээг тогтмол хугацаанд шинжлэх ухаанд суурилан боловсруулж, байгаль орчин, нийгэм, эдийн засгийн салбар, бүс нутаг тус бүрийн эмзэг байдал, эрсдэлийг тодорхойлох зохицуулалтыг тусгасан. Үнэлгээний үр дүнд үндэслэн сааруулах болон дасан зохицох бодлого, арга хэмжээг төлөвлөх, үндэсний болон орон нутгийн хөгжлийн бодлого, Үндэсний дасан зохицох төлөвлөгөө боловсруулахад ашиглах эрх зүйн үндсийг бүрдүүлсэн. Мөн уур амьсгалын өөрчлөлтийн нөлөөлөл, эмзэг байдал, эрсдэлийн үнэлгээний үр дүнг үндэсний платформоор дамжуулан олон нийтэд нээлттэй мэдээлэх замаар мэдээллийн ил тод байдлыг хангахаар тусгасан.

Хүлэмжийн хийн үндэсний тооллогын хүрээнд үндэсний зохицуулагч байгууллага нь олон улсын хүлээн зөвшөөрөгдсөн аргачлал, удирдамжид нийцүүлэн хүлэмжийн хийн ялгарал, шингээлтийн тооллого, тайлан, хэтийн төлөв, төсөөллийг боловсруулж, холбогдох байгууллагаар баталгаажуулах зохицуулалтыг тусгасан. Мөн салбарын төрийн байгууллага, эрдэм шинжилгээний байгууллагатай хамтран ялгарал, шингээлтийн коэффициент

боловсруулах, шинэчлэх, шаардлагатай өгөгдөл, мэдээллийг цуглуулах, үндэсний хэмжээнд нэгдсэн тооллого хийх тогтолцоог бүрдүүлсэн.

Түүнчлэн Парисын хэлэлцээрийн Ил тод байдлын сайжруулсан тогтолцоо (Enhanced Transparency Framework)-ийн шаардлагын хүрээнд хүлэмжийн хийн үндэсний тооллого, ил тод байдлын тайланг олон улсын гэрээ, шийдвэр, удирдамжид нийцүүлэн тогтоосон хугацаанд хүргүүлэх, олон нийтэд нээлттэй мэдээлэх зохицуулалтыг тусгасан.

Энэ бүлэгт мөн Парисын хэлэлцээрийн 6 дугаар зүйлтэй холбоотой “харгалзах тохируулга” хийх эрх зүйн үндсийг тусгасан бөгөөд олон улсад шилжүүлэн тооцох ялгарлын бууралтын үр дүн (ITMO)-г шилжүүлэхдээ Үндэсний тодорхойлсон хувь нэмэр (ҮТХН)-ийн зорилтод нийцүүлэх, давхар тооллого үүсгэхгүй байх, карбон бүртгэлийн системд бүртгэх, зөвшөөрлийн үндсэн дээр олон улсын журам, удирдамжид нийцүүлэн харгалзах тохируулга хийх зохицуулалтыг тусгасан. Мөн Монгол Улсаас олон улсад шилжүүлэхээр зөвшөөрөөгүй карбон кредит, сааруулалтын үр дүнд харгалзах тохируулга хийхгүй байх зарчмыг тогтоосон.

Үүнээс гадна төрийн болон орон нутгийн өмчит хуулийн этгээд, бусад байгууллагын үйл ажиллагаатай холбоотой уур амьсгалын эрсдэлийн үнэлгээ хийх зохицуулалтыг тусгаж, улсын болон орон нутгийн төсвийн хөрөнгөөр хэрэгжүүлэх уур амьсгалын өөрчлөлтийг сааруулах, дасан зохицох, даван туулах төсөл, хөтөлбөрүүдэд уур амьсгалын эрсдэлийн үнэлгээ хийлгэх шаардлага тавьсан нь уур амьсгалын эрсдэлийг хөгжлийн төлөвлөлт, хөрөнгө оруулалтын шийдвэр гаргалтад тусгах эрх зүйн үндсийг бүрдүүлж байгаа онцлогтой.

Дөрөвдүгээр бүлэгт уур амьсгалын өөрчлөлтөд дасан зохицох бодлого, Үндэсний дасан зохицох төлөвлөгөө болон уур амьсгалын өөрчлөлтийн сөрөг нөлөөллийг бууруулахтай холбогдсон зохицуулалтыг тусгасан.

Энэ бүлгээр уур амьсгалын өөрчлөлтийн сөрөг нөлөөлөл, эрсдэлийг бууруулах, нийгэм, эдийн засаг, байгаль орчны салбаруудын дасан зохицох болон даван туулах чадавхыг бэхжүүлэхтэй холбоотой харилцааг зохицуулсан. Монгол Улсын хувьд ган, зуд, цөлжилт, усны нөөцийн хомсдол, бэлчээрийн доройтол, мөсөн голын хайлалт, гамшигт үзэгдлийн давтамж нэмэгдэх зэрэг уур амьсгалын өөрчлөлтийн нөлөөлөл эрчимжиж байгаа нөхцөлд дасан зохицох бодлого, төлөвлөлтийг үндэсний хөгжлийн бодлоготой уялдуулан хэрэгжүүлэх эрх зүйн үндсийг бүрдүүлсэн.

Тодруулбал, уур амьсгалын өөрчлөлтийн нөлөөлөл, эмзэг байдал, эрсдэлийн үнэлгээнд үндэслэн Үндэсний дасан зохицох төлөвлөгөөг боловсруулж, Үндэсний тодорхойлсон хувь нэмэр (ҮТХН)-ийн зорилттой уялдуулан хэрэгжүүлэх зохицуулалтыг тусгасан. Мөн энэхүү төлөвлөгөөг Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлого, таван жилийн үндсэн чиглэл, Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөр болон хөгжлийн бодлого, төлөвлөлтийн бусад баримт бичигтэй уялдуулан боловсруулах замаар уур амьсгалын өөрчлөлтийн асуудлыг хөгжлийн бодлого, төлөвлөлтийн тогтолцоонд нэгтгэх нөхцөлийг бүрдүүлсэн.

Үүнээс гадна Үндэсний дасан зохицох төлөвлөгөөнд туссан арга хэмжээг улсын болон орон нутгийн төсөв, хөрөнгө оруулалт, орон нутгийн хөгжлийн сангийн төлөвлөлтөд тусган хэрэгжүүлэхээр зохицуулсан нь дасан зохицох бодлого, арга хэмжээг тогтвортой санхүүжүүлэх эрх зүйн үндсийг бүрдүүлж байна.

Мөн нийгэм, эдийн засгийн хувьд уур амьсгалын өөрчлөлтийн нөлөөлөлд хамгийн эмзэг, өртөмтгий салбар, бүлгийн дасан зохицох болон даван туулах чадавхыг бэхжүүлэх асуудлыг тэргүүлэх чиглэл болгон тусгасан. Үүнд мал аж ахуй, ус, газар тариалан, эрүүл мэнд зэрэг салбарууд, түүнчлэн орон нутгийн иргэд, малчид, эмзэг бүлгийн иргэдийг хамруулан уур амьсгалын эрсдэлийг даван туулах чадавхыг нэмэгдүүлэх арга хэмжээг жил бүр төлөвлөж, санхүүжилтийн эх үүсвэрийг тодорхойлон хэрэгжүүлэхээр зохицуулсан.

Түүнчлэн уур амьсгалын өөрчлөлтөд дасан зохицох мэдлэг, боловсрол, чадавхыг нэмэгдүүлэх зорилгоор бүх шатны боловсролын байгууллага болон олон нийтэд чиглэсэн сургалт, мэдээлэл, чадавх бэхжүүлэх арга хэмжээг хэрэгжүүлэхээр тусгасан.

Мөн Үндэсний дасан зохицох төлөвлөгөөний хэрэгжилтийг жил бүр үнэлж, тайлагнах, тайланг олон улсын хүлээн зөвшөөрөгдсөн аргачлал, удирдамжид нийцүүлэн боловсруулах зохицуулалтыг тусгасан нь Парисын хэлэлцээр болон олон улсын тайлагналын тогтолцоотой нийцсэн дасан зохицох бодлогын хэрэгжилтийн хяналт-шинжилгээ, үнэлгээний үндсийг бүрдүүлж байна.

Тавдугаар бүлэгт уур амьсгалын өөрчлөлтийг сааруулах, хүлэмжийн хийн ялгарлыг бууруулах, шингээлтийг нэмэгдүүлэх бодлого, арга хэмжээ болон Үндэсний тодорхойлсон хувь нэмрийн хэрэгжилттэй холбогдсон харилцааг тусгасан.

Энэ бүлгээр хүлэмжийн хийн ялгарлыг бууруулах, урьдчилан сэргийлэх, нүүрстөрөгчийн шингээлтийг нэмэгдүүлэх бодлого, төлөвлөлт, Үндэсний тодорхойлсон хувь нэмэр (ҮТХН)-ийн зорилтын хэрэгжилт, тайлагнал, үнэлгээтэй холбоотой харилцааг зохицуулсан. Монгол Улсын хувьд эрчим хүч, хөдөө аж ахуй, газар ашиглалт, тээвэр, барилга, хог хаягдал зэрэг салбарууд нь хүлэмжийн хийн ялгарлын гол эх үүсвэр болж байгаа тул эдгээр салбарын бодлого, төлөвлөлтийг уур амьсгалын өөрчлөлтийг сааруулах зорилттой уялдуулах эрх зүйн үндсийг бүрдүүлсэн.

Хүлэмжийн хийн үндэсний тооллого, ялгарал, шингээлтийн хэтийн төлөв, төсөөлөлд үндэслэн уур амьсгалын өөрчлөлтийг сааруулах урт болон дунд хугацааны бодлого, стратеги, төлөвлөгөөг батлах, Үндэсний тодорхойлсон хувь нэмрийг таван жил тутам шинэчлэн батлах зохицуулалтыг тусгасан. Ингэснээр Парисын хэлэлцээрийн 4 дүгээр зүйлд заасан ҮТХН-ээ тогтмол шинэчлэх, ахицтай зорилт дэвшүүлэх олон улсын үүргийг хэрэгжүүлэх эрх зүйн үндэс бүрдэж байна.

Мөн хүлэмжийн хийг ялгаруулагч болон шингээгч салбар тус бүрээр хүлэмжийн хийн ялгарлыг бууруулах, урьдчилан сэргийлэх, шингээлтийг нэмэгдүүлэх зорилт, арга хэмжээ, шалгуур үзүүлэлтийг бодлого, төлөвлөлтийн баримт бичигт тусгахаар зохицуулсан. Салбарын яамд болон орон нутгийн байгууллагууд өөрсдийн хөгжлийн бодлого, төлөвлөлтөд уур амьсгалын өөрчлөлтийг сааруулах зорилт, арга хэмжээг тусган хэрэгжүүлэх үүрэгтэй байхаар тусгасан нь уур амьсгалын өөрчлөлтийн асуудлыг салбар дундын хөгжлийн бодлогод нэгтгэх ач холбогдолтой.

Түүнчлэн уур амьсгалын өөрчлөлтийг сааруулах бодлого, арга хэмжээг хэрэгжүүлэхдээ эдийн засаг, нийгэм, байгаль орчинд үзүүлэх үр нөлөө, эрсдэлийг харгалзан үзэх, тэгш хүртээмжтэй шилжилтийн зарчмыг хангах нөхцөлийг бүрдүүлсэн. Мөн хувийн хэвшлийн байгууллага өөрийн үйл ажиллагаанаас үүдэлтэй хүлэмжийн хийн ялгарал, шингээлтийг тооцох, бууруулах, шингээлтийг нэмэгдүүлэх арга хэмжээг хэрэгжүүлэхийг дэмжих зохицуулалтыг тусгасан нь төр-хувийн хэвшлийн хамтын ажиллагааг өргөжүүлэх ач холбогдолтой.

Энэ бүлэгт байгууллага болон төслийн түвшний хүлэмжийн хийн ялгарлын тооцоо, хэмжилт, тайлагнал, баталгаажуулалтын заавар, аргачлалыг үндэсний зохицуулагч байгууллага баталж, хэрэгжилтэд арга зүйн дэмжлэг үзүүлэхээр зохицуулсан.

Уур амьсгалын өөрчлөлтийг сааруулах бодлого, арга хэмжээний хэрэгжилтийг жил бүр үнэлж, тайлагнах тогтолцоог бүрдүүлсэн бөгөөд бодлого боловсруулах, хэрэгжүүлэх хүрээнд институцийн болон хүний нөөцийн чадавхыг бэхжүүлэх, олон нийтийн мэдлэг, оролцоог нэмэгдүүлэх арга хэмжээг тусгасан.

Үндэсний тодорхойлсон хувь нэмрийн зорилтын үр дүнг тооцох, тайлагнах хүрээнд үндэсний зохицуулагч байгууллага нь хүлэмжийн хийн үндэсний тооллого болон холбогдох

мэдээлэлд үндэслэн ҮТХН-ийн зорилтын хэрэгжилтийн үр дүнг тооцож, ил тод байдлын тайланг олон улсад хүлээн зөвшөөрөгдсөн аргачлалын дагуу боловсруулан олон улсын байгууллагад хүргүүлэхээр зохицуулсан. Энэ нь Парисын хэлэлцээрийн Ил тод байдлын сайжруулсан тогтолцоо (Enhanced Transparency Framework)-ийн шаардлагыг хэрэгжүүлэх үндсэн зохицуулалт болж байна.

Мөн хоёр болон олон талт карбон зах зээлийн хүрээнд хэрэгжсэн төсөл, хөтөлбөрөөс үүссэн баталгаажсан сааруулалтын үр дүнг талуудын тохиролцооны үндсэн дээр ҮТХН-ийн зорилтын биелэлтэд тооцож, Монгол Улсын нутаг дэвсгэрт бий болсон боловч олон улсад шилжүүлээгүй сааруулалтын үр дүнг ҮТХН-ийн хэрэгжилтэд ашиглах боломжийг тусгасан. Энэ нь Парисын хэлэлцээрийн 6 дугаар зүйл болон олон улсын карбон зах зээлийн зохицуулалттай уялдсан үндэсний эрх зүйн орчныг бүрдүүлж байгаагаараа онцлогтой.

Зургаадугаар бүлэгт ногоон санхүүжилтийн эх үүсвэр, санхүүгийн хэрэгсэл, шалгуур, нийцэл, ил тод байдал, тайлагнал, баталгаажуулалттай холбоотой харилцааг тусгасан.

Энэ бүлгээр уур амьсгалын өөрчлөлтийг сааруулах, дасан зохицох, даван туулах бодлого, арга хэмжээг хэрэгжүүлэх санхүүгийн тогтолцоо, ногоон санхүүжилтийн эх үүсвэр, шалгуур, хяналт, ил тод байдалтай холбоотой харилцааг зохицуулсан. Уур амьсгалын өөрчлөлтийн зорилтыг хэрэгжүүлэхэд урт хугацааны тогтвортой санхүүжилтийн тогтолцоо шаардлагатай тул ногоон болон уур амьсгалын санхүүжилтийг төсөв, санхүүгийн бодлого, хувийн хэвшлийн хөрөнгө оруулалт, олон улсын санхүүжилттэй уялдуулан хэрэгжүүлэх эрх зүйн үндсийг бүрдүүлсэн.

Тодруулбал, ногоон санхүүжилтийн бодлого, санхүүгийн хөшүүргийг Монгол Улсын Үндэсний тодорхойлсон хувь нэмэр (ҮТХН)-ийн зорилт, төсөв, мөнгөний бодлого болон ногоон санхүүжилтийн стратегитай нийцүүлэх зохицуулалтыг тусгасан. Мөн уур амьсгалын өөрчлөлтийн чиглэлээр хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээг улсын болон орон нутгийн төсөвт тусгахдаа зардал, үр ашиг, эдийн засгийн өгөөж, төсөвт үзүүлэх нөлөөлөлд үндэслэн эрэмбэлэх, үр ашиг багатай, давхардсан төслүүдийг санхүүжүүлэхгүй байх зарчмыг тогтоосон.

Энэ бүлэгт карбон зах зээл, ногоон санхүүжилтийн механизмтай холбоотой төсвийн зардал, татаас, урамшууллыг улсын төсөв, дунд хугацааны төсвийн хүрээтэй уялдуулан хэрэгжүүлэхээр тусгасан нь төсвийн сахилга бат, санхүүгийн тогтвортой байдлыг хангах ач холбогдолтой. Ногоон санхүүжилтийн эх үүсвэрийг улсын болон орон нутгийн төсөв, олон улсын уур амьсгалын сан, хөгжлийн сан, зээл, буцалтгүй тусламж, хандив, төр-хувийн хэвшлийн түншлэл, байгаль орчин, уур амьсгалын сан болон бусад хууль ёсны эх үүсвэрээс бүрдүүлэхээр зохицуулсан.

Ногоон санхүүжилтийг буцалтгүй тусламж, ногоон бонд, зээл, холимог санхүүжилт, даатгал, батлан даалт, татварын дэмжлэг зэрэг олон төрлийн санхүүгийн хэрэгслээр дамжуулан олгож болохоор тусгасан бөгөөд эдгээр нь Монгол Улсын Төсвийн тухай хууль, Төсвийн тогтвортой байдлын тухай хууль, Өрийн удирдлагын тухай хууль, Татварын ерөнхий хууль болон бусад холбогдох хууль тогтоомжийн шаардлагад нийцсэн байх зарчмыг тогтоосон.

Уур амьсгалын хөрөнгө оруулалтад үзүүлэх урамшуулал, дэмжлэг нь хувийн хэвшлийн хөрөнгө оруулалтыг татах, санхүүгийн эрсдэлийг бууруулах, уур амьсгалын өөрчлөлтөд дасан зохицсон, хүлэмжийн хийн ялгарал багатай хөгжлийг дэмжихэд чиглэхээр зохицуулсан. Ногоон санхүүжилт олгохдоо ногоон таксономи, шалгуур, хэмжилт-тайлагнал-баталгаажуулалтын шаардлагыг хангасан эсэхэд үндэслэх бөгөөд байгаль орчин, нийгэмд сөрөг нөлөө үзүүлэхгүй байх “do no significant harm” зарчмыг баримтлахаар тусгасан.

Уур амьсгалын санхүүжилтэд хамрагдах төсөл, хөтөлбөр, үйл ажиллагаа нь уур амьсгалын өөрчлөлтийг сааруулах, дасан зохицох, даван туулах, эрсдэл болон гарз хохирлыг бууруулахад бодит, хэмжигдэхүйц, баталгаажихуйц хувь нэмэр оруулж байх шаардлагыг тусгасан. Мөн ногоон санхүүжилтийн үр дүнг хэмжих, тайлагнах, баталгаажуулахад энэ хуульд заасан хэмжилт-тайлагнал-баталгаажуулалтын тогтолцоог ашиглах зохицуулалтыг тусгасан нь олон улсын ногоон санхүүжилтийн нийтлэг шаардлагатай нийцэж байна.

Түүнчлэн ногоон болон уур амьсгалын санхүүжилтийн орлогын урсгалын бүртгэл, тайлагнал, ил тод байдлыг хангах тогтолцоог бүрдүүлж, санхүүжилтийн шийдвэр, эх үүсвэр, зориулалт, хэрэгжилтийн явц, үр дүн, байгаль орчин, уур амьсгалын нөлөөллийн талаарх мэдээллийг ил тод, нийтэд нээлттэй байлгахаар тусгасан. Ногоон санхүүжилтийн үр дүн болон уур амьсгалын санхүүжилтийн үр дүнг хараат бус, магадлан итгэмжлэгдсэн мэргэжлийн байгууллагаар баталгаажуулах бөгөөд уг үр дүнг Үндэсний тодорхойлсон хувь нэмрийн хэрэгжилтийн ил тод байдлын тайланд тусган тайлагнахаар зохицуулсан.

Мөн банк, санхүүгийн байгууллагуудын байгаль орчин, нийгэм, засаглалын (ESG) эрсдэлийг үнэлэх, удирдах, тайлагнах, хэрэгжилтэд хяналт тавих журмыг Монголбанк болон Санхүүгийн зохицуулах хороо хамтран батлахаар тусгасан нь санхүүгийн салбарын тогтвортой, хариуцлагатай санхүүжилтийн тогтолцоог хөгжүүлэх эрх зүйн үндсийг бүрдүүлж байна.

Долоодугаар бүлэгт нүүрстөрөгчийн зах зээлийн хэлбэр, карбон кредитийг үүсгэх, баталгаажуулах, бүртгэх, эзэмших, шилжүүлэгтэй холбоотой харилцааг тусгасан.

Энэ бүлгээр карбон зах зээлийн тогтолцоо, карбон кредит, сааруулалтын үр дүн, олон улсад шилжүүлэн тооцох сааруулалтын үр дүн (ITMO), карбон бүртгэл, шилжүүлэг, хэмжилт-тайлагнал-баталгаажуулалт (MRV), газрын ашиглалттай холбоотой карбон кредитийн зохицуулалт зэрэг харилцааг зохицуулсан.

Хуулийн төсөлд карбон зах зээлийг олон талт, хоёр талт, үндэсний, дүйцүүлэх болон сайн дурын хэлбэртэй байхаар ангилж, эдгээр зах зээлийн хүрээнд хэрэгжих төсөл, хөтөлбөрөөс сааруулалтын үр дүн, карбон кредит болон олон улсад шилжүүлэн тооцох сааруулалтын үр дүнг үүсгэхээр зохицуулсан. Карбон зах зээлийн үйл ажиллагаа нь Монгол Улсын Үндэсний тодорхойлсон хувь нэмэр (ҮТХН)-ийн зорилт, уур амьсгалын өөрчлөлтийн талаар баримтлах төрийн бодлоготой нийцсэн байх, бодит, хэмжигдэхүйц, нэмэлт, баталгаажсан үр дүнд суурилах, давхар тооллого үүсгэхгүй байх, байгаль орчин, нийгэм, эдийн засагт сөрөг нөлөө үзүүлэхгүй байх зэрэг үндсэн зарчмыг хангахаар тусгасан.

Карбон зах зээлийн төсөл, хөтөлбөрийг хэрэгжүүлэхдээ орон нутгийн иргэдтэй урьдчилан зөвлөлдөх, санал авах, тухайн орон нутгийн өөрөө удирдах байгууллагын дэмжсэн тогтоолд үндэслэх шаардлагыг тусгасан нь орон нутгийн оролцоо, үр өгөөжийн шударга хуваарилалтыг хангах ач холбогдолтой. Сонирхогч талуудын тэгш оролцоог хангах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх, үр ашгийг шударгаар хуваарилах зарчмыг тусгасан нь тэгш хүртээмжтэй шилжилтийн зарчимтай уялдаж байна.

Карбон зах зээлийн төсөл, хөтөлбөр хэрэгжүүлэгч нь үндэсний карбон бүртгэлийн системд бүртгүүлж, холбогдох тодорхойлолт, зөвшөөрлийг авах зохицуулалтыг тусгасан. Ялангуяа хоёр талт болон олон талт карбон зах зээлийн хүрээнд хэрэгжих төсөл, хөтөлбөр болон ITMO-гийн шилжүүлэгт “зөвшөөрсөн тухай тодорхойлолт” олгох бөгөөд уг тодорхойлолтод ҮТХН-т тооцох хэмжээ, эрсдэлийн санд хуримтлуулах хувь хэмжээ, харгалзах тохируулга хийх шаардлага, давхар тооллогоос сэргийлэх мэдээлэл, хэмжилт-тайлагнал-баталгаажуулалтын шаардлага, төслийн хугацаа, буцаалтын эрсдэлийн удирдлага зэрэг асуудлыг тусгахаар зохицуулсан.

Хоёр болон олон талт карбон зах зээлийн хүрээнд сааруулалтын үр дүн урт хугацаанд хадгалагдахгүй болох, хэтрүүлэн тооцох, байгалийн болон бусад хүчин зүйлээс шалтгаалан буцаан алдагдах эрсдэлийг бууруулах зорилгоор баталгаажсан сааруулалтын үр дүнгийн тодорхой хувийг “эрсдэлийн сан”-д төвлөрүүлэх зохицуулалтыг тусгасан. Энэ нь карбон зах зээлийн орчны бүрэн бүтэн байдал, сааруулалтын үр дүнгийн тогтвортой байдлыг хангах эрх зүйн механизм болж байна.

Карбон кредитийн бүртгэл, эзэмшил, шилжүүлэг, худалдаа, арилжаатай холбоотой эрх зүйн үндсийг тодорхойлсон бөгөөд баталгаажсан карбон кредит нь үндэсний бүртгэлийн системд бүртгэгдсэнээр эзэмших, ашиглах, шилжүүлэх, худалдах эрх үүсэхээр зохицуулсан. Улсын болон орон нутгийн төсвийн санхүүжилтээр шууд хэрэгжээгүй төслөөс үүссэн карбон кредитийн өмчлөл, үр өгөөжийн хуваарилалтыг төслийн оролцогч талуудын хооронд байгуулсан гэрээгээр зохицуулах бөгөөд оролцогч талуудын эрх, үүрэг, үр ашгийн хуваарилалтыг тодорхой тусгах шаардлага тавьсан.

Газрын ашиглалттай холбоотой карбон кредитийн хүрээнд газар өмчлөх, эзэмших, ашиглах эрхийг хязгаарлахгүй байх зарчмыг тогтоосон бөгөөд газрын өмчлөгч, эзэмшигч, ашиглагч болон төсөл хэрэгжүүлэгч этгээдийн эрх, үүргийг гэрээгээр зохицуулахаар тусгасан. Мөн хамтын ашиглалтын шинжтэй бэлчээр болон төрийн нийтийн өмчийн газарт хэрэгжүүлэх төслөөс үүсэх үр өгөөж, орлогын хуваарилалтыг орон нутгийн иргэд, малчдын оролцоонд үндэслэсэн шударга зарчмаар тогтоох зохицуулалтыг тусгасан нь орон нутгийн эрх ашиг, хамтын ашиглалтыг хамгаалах ач холбогдолтой.

Энэ бүлэгт мөн сааруулалтын үр дүн үүсгэх төсөл, хөтөлбөрийн хэмжилт, тайлагнал, баталгаажуулалтын тогтолцоог зохицуулсан. Төсөл хэрэгжүүлэгч нь жил бүр хүлэмжийн хийн ялгарлын хэмжилт, тайлагнал, баталгаажуулалтыг батлагдсан аргачлалын дагуу хийж, холбогдох байгууллагад хүргүүлэх бөгөөд баталгаажуулалтыг олон улсын болон үндэсний стандартын дагуу итгэмжлэгдсэн, хараат бус хөндлөнгийн байгууллагаар гүйцэтгүүлнэ. Мөн сайн дурын карбон зах зээлийн хүрээнд хэрэгжсэн төслийн тайланг баталгаажуулсны дараа үндэсний байгууллагад хүргүүлэх зохицуулалтыг тусгасан нь үндэсний бүртгэл, УТХН-ийн тайлагналтай уялдуулах ач холбогдолтой.

Наймдугаар бүлэгт уур амьсгалын өөрчлөлттэй холбоотой мэдээллийн сан, мэдээллийн тогтолцоо, ил тод байдал, тайлагнал, хяналт-шинжилгээ, үнэлгээтэй холбоотой харилцааг тусгана.

Энэ бүлгээр уур амьсгалын өөрчлөлтийн талаарх мэдээллийн нэгдсэн тогтолцоо, үндэсний платформ, хяналт-шинжилгээ, үнэлгээ, олон улсын тайлагнал, мэдээллийн сан болон карбон бүртгэлийн системтэй холбоотой харилцааг зохицуулсан. Уур амьсгалын өөрчлөлтийн бодлого, арга хэмжээг үр дүнтэй хэрэгжүүлэхэд мэдээллийн нэгдсэн тогтолцоо, ил тод байдал, олон талын оролцоо, тогтмол тайлагнал чухал ач холбогдолтой тул энэ чиглэлийн институцийн болон техникийн үндсийг бүрдүүлсэн.

Уур амьсгалын өөрчлөлтийн үндэсний платформыг төр, хувийн хэвшил, иргэний нийгэм, шинжлэх ухааны байгууллага болон олон улсын түншүүдийн мэдээлэл солилцох, зөвлөлдөх, хамтын ажиллагааг дэмжих үндэсний мэдээллийн систем байхаар зохицуулсан. Мөн уур амьсгалын өөрчлөлтийн судалгаа, төсөл, хөтөлбөрийн үр дүн, хүлэмжийн хийн үндэсний тооллоготой холбоотой мэдээллийг олон нийтэд ил тод, нээлттэй мэдээлэх, платформын удирдлага, зохион байгуулалтыг хариуцах тогтолцоог тусгасан.

Уур амьсгалын өөрчлөлтийг сааруулах, дасан зохицох, гарз хохирлыг бууруулах, технологи дамжуулах, чадавх бэхжүүлэх, ногоон санхүүжилтийн хэрэгжилтийн үр дүнг үнэлэх хяналт-шинжилгээ, үнэлгээний тогтолцоог бүрдүүлэх зохицуулалтыг тусгасан. Хуулийн хэрэгжилт, уур амьсгалын бодлого, арга хэмжээ, ногоон болон уур амьсгалын санхүүжилтийн үр дүнгийн үнэлгээг жил бүр хийж, хараат бус мэргэжлийн байгууллагаар

баталгаажуулан Засгийн газарт танилцуулах тогтолцоог бий болгосон нь бодлогын хэрэгжилтийн үр нөлөө, ил тод байдлыг хангах ач холбогдолтой.

Түүнчлэн Монгол Улсын олон улсын гэрээ, тэдгээрийн хүрээнд батлагдсан шийдвэр, удирдамжийн дагуу хүлэмжийн хийн үндэсний тооллогын тайлан, Үндэсний тодорхойлсон хувь нэмрийн хэрэгжилтийн ил тод байдлын тайлан, үндэсний тайлан, илтгэл, карбон кредит болон олон улсад шилжүүлэн тооцох сааруулалтын үр дүнгийн талаарх мэдээлэл, уур амьсгалын санхүүжилтийн тайланг тогтоосон хугацаанд боловсруулж, хүргүүлэх зохицуулалтыг тусгасан. Мөн эдгээр тайлан, мэдээллийн үнэн зөв, бүрэн бүтэн байдлыг хангах зорилгоор дотоодын хяналт, чанарын баталгаажуулалт болон олон улсын техникийн шинжилгээнд хамруулах зохицуулалтыг тусгасан нь Парисын хэлэлцээрийн Ил тод байдлын сайжруулсан тогтолцооны шаардлагатай нийцэж байна.

Мөн аж ахуйн нэгж, байгууллага нь уур амьсгалын өөрчлөлттэй холбоотой эрсдэл, хүлэмжийн хийн ялгарал, сааруулалт, дасан зохицох арга хэмжээний талаарх мэдээллийг олон улсад хүлээн зөвшөөрөгдсөн тайлагналын стандартын дагуу сайн дурын үндсэн дээр ил тод мэдээлж болох зохицуулалтыг тусгасан нь хувийн хэвшлийн ил тод байдал, тогтвортой засаглалыг дэмжих ач холбогдолтой.

Уур амьсгалын өөрчлөлтийн нөлөөлөл, эмзэг байдал, эрсдэлийн үнэлгээ, дасан зохицох болон сааруулах арга хэмжээний талаарх мэдээллийг хадгалах, шинэчлэх мэдээллийн сан болон карбон бүртгэлийн системийн эрх зүйн үндсийг тусгасан. Төрийн болон орон нутгийн байгууллага, эрдэм шинжилгээний байгууллага, хувийн хэвшил нь холбогдох өгөгдөл, мэдээллийг тогтоосон журмын дагуу мэдээллийн санд хүргүүлэх үүрэгтэй байхаар зохицуулсан.

Үндэсний зохицуулагч байгууллага нь хүлэмжийн хийн үндэсний тооллогын мэдээллийн систем болон карбон бүртгэлийн системийн удирдлага, зохион байгуулалтыг хариуцах бөгөөд карбон бүртгэлийн систем нь үндэсний тооллогын систем болон олон улсын карбон бүртгэлийн системтэй уялдсан байхаар тусгасан. Мөн мэдээллийн сан, бүртгэлийн системийг Үндэсний платформын бүрэлдэхүүн хэсэг байхаар зохицуулж, мэдээллийн ил тод, хүртээмжтэй байдлыг хангахын зэрэгцээ үндэсний аюулгүй байдал, нууцлалтай холбоотой мэдээллийг хууль тогтоомжийн дагуу хамгаалах зохицуулалтыг тусгасан болно.

Есдүгээр бүлэгт хориглох үйл ажиллагаа, уур амьсгалын өөрчлөлтийн тухай хуулийг зөрчсөн тохиолдолд хүлээлгэх хариуцлага, хууль хүчин төгөлдөр болох зохицуулалтыг тусгасан.

Энэ бүлгээр уур амьсгалын өөрчлөлтийн тухай хууль тогтоомжийн хэрэгжилтийг хангах хүрээнд хориглох үйл ажиллагаа, хууль зөрчсөн этгээдэд хүлээлгэх хариуцлага болон хууль хүчин төгөлдөр мөрдөгдөх хугацаатай холбоотой харилцааг зохицуулсан.

Үндэсний тодорхойлсон хувь нэмэр (ҮТХН)-ийн зорилтыг хангахтай холбоотой зохицуулалттай карбон кредитийг эрх бүхий байгууллагын зөвшөөрсөн тухай тодорхойлолтгүйгээр худалдах, арилжих, шилжүүлэхийг хориглосон. Энэхүү зохицуулалт нь карбон зах зээлийн үйл ажиллагааг үндэсний зорилт, олон улсын шаардлагатай уялдуулах, давхар тооллогоос сэргийлэх, Монгол Улсын ҮТХН-ийн зорилтын бүрэн бүтэн байдлыг хамгаалах ач холбогдолтой.

Ногоон санхүүжилтийн хүрээнд хэрэгжүүлж буй төсөл, хөтөлбөр, үйл ажиллагааны байгаль орчин, нийгэм, уур амьсгалын үр нөлөөний талаар худал, төөрөгдүүлсэн, баталгаажаагүй мэдээлэл ашиглан тайлагнахыг хориглосон нь “greenwashing” буюу бодит бус ногоон тайлагналаас урьдчилан сэргийлэх, ногоон санхүүжилтийн ил тод байдал, итгэлцлийг хангах эрх зүйн үндсийг бүрдүүлж байна.

Энэ бүлэгт хууль зөрчсөн хүн, хуулийн этгээдэд Эрүүгийн хууль, Зөрчлийн тухай хууль болон бусад холбогдох хууль тогтоомжид заасан хариуцлага хүлээлгэхээр зохицуулсан. Түүнчлэн төрийн албан тушаалтан энэ хуулийг зөрчсөн боловч гэмт хэрэг, зөрчлийн шинжгүй тохиолдолд Төрийн албаны тухай хуульд заасан сахилгын хариуцлага хүлээлгэхээр тусгасан.

Мөн ногоон санхүүжилттэй холбоотой зөрчил гаргасан нь тогтоогдсон тохиолдолд тухайн санхүүжилтийг түдгэлзүүлэх, цуцлах арга хэмжээ авч, холбогдох хууль тогтоомжийн дагуу хариуцлага тооцох зохицуулалтыг тусгасан нь ногоон болон уур амьсгалын санхүүжилтийн сахилга, хариуцлагыг хангах ач холбогдолтой.

Энэ бүлэгт хуулийг дагаж мөрдөх хугацааг тогтоож, хууль хүчин төгөлдөр болох эрх зүйн үндсийг тодорхойлсон болно.

Дөрөв. Хууль батлагдсанаар үүсэх нийгэм, эдийн засаг, хууль зүйн үр дагавар

Уур амьсгалын өөрчлөлтийн тухай хууль батлагдсанаар дараах эерэг үр дүн гарна. Үүнд:

1. Уур амьсгалын өөрчлөлтийн нөлөөллийг бууруулах, дасан зохицох, хүлэмжийн хийн ялгарлыг бууруулах талаар олон улсын өмнө хүлээсэн үүргийг хэрэгжүүлэхтэй холбоотой хууль, эрх зүйн орчин бүрдэж, хүлэмжийн хийн тооллого, тооцоолол, уур амьсгалын өөрчлөлтийн эмзэг байдал болон эрсдэлийн үнэлгээний нэгдсэн зохицуулалт бий болно.

2. Уур амьсгалын өөрчлөлттэй холбоотой мэдээллийн санг бүрдүүлж, судалгаанд үндэслэсэн нэгдсэн бодлого төлөвлөлтөөр уур амьсгалын өөрчлөлтийг сааруулах болон дасан зохицох арга хэмжээг авч хэрэгжүүлэхэд шинжлэх ухааны үндэслэлтэй хариу арга хэмжээ авах боломж бүрдэнэ.

3. Хүлэмжийн хийн ялгарлыг бууруулах, шингээлтийг нэмэгдүүлэхтэй холбоотой Монгол Улсын хэрэгжүүлж буй үйл ажиллагаанд олон улсын болон төр, хувийн хэвшлийн салбарын хөрөнгө оруулалтыг нэмэгдүүлэх, олон улсын механизмыг нэвтрүүлэх боломж бүрдэнэ.

4. Шинжлэх ухааны үндэслэлтэй судалгаа, мэдээлэлд суурилсан бодлого, хариу арга хэмжээг хэрэгжүүлэх салбар хоорондын зохицуулалт боловсронгуй болж, Засгийн газар уур амьсгалын өөрчлөлтийн улмаас учрах эрсдэлийг удирдах, байгалийн гамшгаас сэргийлэхтэй холбоотой салбар дундын уялдаа холбоог сайжруулах, Монгол Улс Парисын хэлэлцээрт нэгдэн орсон улсын хувьд олон улсын өмнө хүлээсэн үүргээ биелүүлэх нөхцөл бүрдэнэ.

5. Карбон зах зээлийн кредит баталгаажуулах, арилжаанд оролцох нөхцөлийг бүрдүүлснээр карбон кредитийг эдийн засгийн эргэлтэд оруулж улс орны нийгэм, эдийн засагт эерэг нөлөөлөл үзүүлнэ.

6. Түүнчлэн, уур амьсгалын санхүүжилт, хөрөнгө оруулалтын тогтолцоог бүрдүүлэх замаар байгаль орчинд ээлтэй, уур амьсгалын өөрчлөлтийг даван туулахад шаардлагатай санхүүжилтийн найдвартай, тогтвортой эх үүсвэрийг бүрдүүлэх боломжтой болно.

7. Хүлэмжийн хийн ялгарлыг бууруулах, шингээлтийг нэмэгдүүлэх, экосистемийн тэнцвэрийг хамгаалах бодлого, арга хэмжээний хэрэгжилт системтэй болно.

8. Хүлэмжийн хийн ялгарлын тэнцлийг хангах зорилтыг үе шаттай хэрэгжүүлэх, технологийн шинэчлэл, инновацыг дэмжих эрх зүйн орчин бүрдэнэ.

Монгол Улсын 2025 оны ДНБ ойролцоогоор 25.1 тэрбум ам.доллар байгаа бөгөөд Үндэсний тодорхойлсон хувь нэмрийн зорилтыг хэрэгжүүлэхэд 2025–2035 онд нийт 14.8

тэрбум ам.долларын нэмэлт хөрөнгө оруулалт шаардлагатай байгаа нь ДНБ-ий 56 орчим хувьтай тэнцэх өндөр дүн юм. Ийм хэмжээний санхүүжилтийг зөвхөн улсын төсвийн эх үүсвэрээр бүрдүүлэх боломж хязгаарлагдмал тул тус хууль батлагдсанаар институцийн зохион байгуулалт, бүртгэл, зөвшөөрөл, хэмжилт, тайлагнал, баталгаажуулалтын тогтолцоо тодорхой болж, хувийн хэвшил болон олон улсын санхүүжилтийг үе шаттайгаар татах боломж бодитоор нэмэгдэнэ. Олон улсын туршлагаас үзэхэд уур амьсгалын эрх зүйн тодорхой орчин бүрдсэн улс орнуудад ногоон хөрөнгө оруулалт дунджаар 2–3 дахин өсөх хандлагатай байна. Монгол Улсын хувьд уур амьсгалын санхүүжилтийн хэрэгцээ 2030 он хүртэл ойролцоогоор 11–12 тэрбум ам.долларт хүрэхээр тооцоологдож байгаа бөгөөд уг хуулийг баталснаар энэ санхүүжилтийн тодорхой хэсгийг олон улсын эх үүсвэр болон хувийн хэвшлээс татах боломж нэмэгдэнэ. Үүний зэрэгцээ уур амьсгалын өөрчлөлтөөс үүдэлтэй эдийн засгийн өсөлтийн алдагдлыг бууруулах стратегийн ач холбогдолтой бөгөөд дундаж температур 1°C-аар өсөхөд ДНБ-ий өсөлт 0.48 нэгж хувиар буурч, сөрөг нөлөө нь хэдэн жилээр үргэлжилдэг нь энэ чиглэлийн эрх зүйн зохицуулалт нэн шаардлагатай байгааг харуулж байна.

Орон нутгийн амьжиргаа болон гамшгийн эдийн засгийн өртгийн хувьд тус хуулийн үр нөлөө өндөр ач холбогдолтой. Сүүлийн жилүүдэд байгалийн гамшгийн давтамж 2.5 дахин нэмэгдэж, 2024 оны байдлаар гамшигтай холбоотой жилийн дундаж хохирол 75 тэрбум төгрөгт хүрсэн байна. Мөн 2023–2024 оны зудын үеэр нийтдээ 8.1 сая мал хорогдож, малчдын орлого буурснаас улбаалан 2024 оны эхний хагас жилийн байдлаар тус салбарын ДНБ-д оруулах хувь нэмэр 27 хувиар буурахад нөлөөлсөн. Ийм нөхцөлд хуулийг баталснаар дасан зохицох бодлого, эрт сэрэмжлүүлэг, ус, бэлчээр, гамшгийн удирдлагыг нэгдсэн байдлаар хэрэгжүүлэх эрх зүйн суурь бүрдэж, эдийн засгийн алдагдлыг бууруулах боломж нэмэгдэнэ. Мөн орон нутгийн иргэдийн дасан зохицох чадавх сайжирч, уур амьсгалын эрсдэлээс үүдэх алдагдлыг 30–50 хувиар бууруулах боломжтой.

Хөдөлмөр эрхлэлтийн хувьд, ногоон шилжилттэй холбоотойгоор сэргээгдэх эрчим хүч, барилга, хөдөө аж ахуй, ойжуулалт зэрэг салбаруудад 2030 он хүртэл 15,000–25,000 шинэ ажлын байр бий болох боломжтой байна. Мөн эрчим хүчний хэмнэлтийн арга хэмжээ хэрэгжүүлснээр аж ахуйн нэгжүүдийн зардал 10–20 хувиар буурах боломжтой бөгөөд энэ нь өрсөлдөх чадварыг нэмэгдүүлэхэд эерэг нөлөө үзүүлнэ.

Уур амьсгалын өөрчлөлтийн тухай хуулийг баталснаар Монгол Улсад нэг талаас уур амьсгалын эрсдэлээс үүдэлтэй жил тутмын эдийн засгийн алдагдал, нийгэм-эдийн засгийн эмзэг байдлыг бууруулах, нөгөө талаас шаардлагатай хөрөнгө оруулалтыг үе шаттайгаар татах, Үндэсний тодорхойлсон хувь нэмрийн зорилтыг хэрэгжүүлэх, олон улсын карбон зах зээлд үр ашигтай оролцох эрх зүйн суурь бүрдэнэ. Өөрөөр хэлбэл, энэхүү хууль нь зөвхөн байгаль орчны салбарын зохицуулалт бус, харин Монгол Улсын эдийн засгийн өрсөлдөх чадвар, санхүүгийн тогтвортой байдал, орон нутгийн амьжиргаа, урт хугацааны хөгжлийн бодлогыг хамгаалах стратегийн ач холбогдол бүхий суурь хууль юм.

Тав. Хуулийн нэр томьёо, ухагдахууны үүслийг нийцүүлсэн талаарх тайлбар

“Уур амьсгалын өөрчлөлтийн тухай” хуулийн төсөлд хэрэглэсэн нэр томьёоны тодорхойлолт, ухагдахууны үүслийг тайлбарлахад Хууль тогтоомжийн тухай хуулийн 33.5-д заасны дагуу Уур амьсгалын өөрчлөлтийн тухай НҮБ-ын суурь конвенц, Парисын хэлэлцээрт заасан нэр томьёо, тодорхойлолт, хэм хэмжээг баримталсан болно. Мөн Үндэсний тодорхойлсон хувь нэмэр (ҮТХН), Ил тод байдлын сайжруулсан тогтолцоо (Enhanced Transparency Framework), карбон кредит, карбон зах зээл, ногоон санхүүжилт, тэгш хүртээмжтэй шилжилт (Just Transition) зэрэг шинэ ойлголтуудыг олон улсын хэрэглээ, агуулгатай нийцүүлэн хуульд тусгасан.

Гадаад нэр томьёог монгол хэлэнд хөрвүүлэхдээ Монгол Улсын хүчин төгөлдөр хууль тогтоомж, Монгол Улсын соёрхон баталсан НҮБҮӨБСК, Парисын хэлэлцээр, бодлогын баримт бичиг, өмнө хэрэглэж ирсэн албан ёсны орчуулга, олон улсын байгууллагуудын баталгаажсан монгол орчуулга болон мэргэжлийн хэрэглээг харгалзан үзсэн. Түүнчлэн нэр томьёоны давхардал, зөрүүтэй хэрэглээг арилгах зорилгоор байгаль орчин, эрчим хүч, санхүү, хөгжлийн бодлого, карбон зах зээлийн чиглэлээр хэрэглэгддэг ойлголтуудыг нэг мөр болгон нийцүүлэхэд анхаарсан.

Хуулийн төсөлд тусгасан зарим шинэ нэр томьёо, тухайлбал “тэгш хүртээмжтэй шилжилт”, “карбон кредит”, “ногоон санхүүжилт”, “Үндэсний тодорхойлсон хувь нэмэр”, “эрсдэлийн сан”, “хэмжилт-тайлагнал-баталгаажуулалт” зэрэг ойлголтууд нь Монгол Улсын эрх зүйн орчинд анх удаа тусгайлан хуульчлагдаж байгаа бөгөөд эдгээрийг олон улсын агуулга, хэрэглээтэй нийцүүлэхийн зэрэгцээ Монгол Улсын нийгэм, эдийн засгийн нөхцөл, эрх зүйн тогтолцоонд нийцүүлэн тодорхойлсон болно.

Нэр томьёог боловсруулахдаа хэл шинжлэл, орчуулгын нэгдмэл байдлыг хангах зорилгоор мэргэжлийн зөвлөхүүд, судлаачид болон холбогдох байгууллагуудын саналыг авч, олон улсын түвшинд өргөн хэрэглэгдэж буй ойлголтын агуулгыг алдагдуулахгүйгээр монгол хэлний найруулга, хэрэглээнд нийцүүлэх зарчмыг баримталсан.

Зургаа. Хуулийн төслийг батлагдсаны дараа боловсруулж, батлуулах журам, аргачлалын тухайд

6.1. Засгийн газрын тогтоолоор батлуулах дараах 4 журмын төслийг БОУАӨЯ боловсруулна. Үүнд:

1. **“Карбон зах зээлийг зохицуулах, карбон кредитийг бүртгэх журам”-ыг** Хуулийн төслийн 7.1.7-д заасны дагуу Засгийн газар батлахаар тусгасан ба уг журмаар карбон зах зээлийн үйл ажиллагааг үндэсний хэмжээнд нэгдсэн зохицуулалт, бүртгэлийн тогтолцоотойгоор хэрэгжүүлэх, карбон кредит, сааруулалтын үр дүнгийн бүртгэл, шилжүүлэг, тайлагнал, баталгаажуулалтыг ил тод, давхар тооллогогүйгээр зохион байгуулах харилцааг нарийвчлан зохицуулна.

Парисын хэлэлцээрийн 6 дугаар зүйлийн хэрэгжилтийг нарийвчлан зохицуулсан 2/СМА.3, 3/СМА.3, СМА.4–СМА.6 болох Парисын хэлэлцээрт оролцогч талуудын бага хурлын шийдвэрүүдээр сааруулалтын үр дүн (mitigation outcomes), олон улсад шилжүүлэн тооцох сааруулалтын үр дүн (ITMO), бүртгэл (registry), хэмжилт, тайлагнал, баталгаажуулалт, зөвшөөрсөн тухай тодорхойлолт (authorization), мөшгих (tracking), харгалзах тохируулга (corresponding adjustment) зэрэг нарийвчилсан техникийн болон институцийн шаардлагыг тогтоосон. Эдгээр шаардлага нь тогтмол шинэчлэгдэж, жил бүрийн Парисын хэлэлцээрт оролцогч талуудын бага хурлын шийдвэрээр хөгжиж байгаа тул хуульд бүх техникийн зохицуулалтыг нэг бүрчлэн тусгах боломжгүй бөгөөд Засгийн газар уян хатан байдлаар олон улсын шаардлагад нийцүүлэн шинэчилж мөрдүүлэх эрх зүйн боломжийг бүрдүүлэх шаардлагатай. Иймд арбон зах зээлд оролцогчдын үйл ажиллагааг зохицуулах, карбон кредит болон олон улсад шилжүүлэн тооцох сааруулалтын үр дүнгийн бүртгэлийг бүртгэх журмыг батлах эрхийг Засгийн газарт олгож, үндэсний, хоёр талт, олон талт, сайн дурын карбон зах зээлийн үйл ажиллагааг олон улсын шаардлагад нийцүүлэн хэрэгжүүлэх хэрэгцээ шаардлага үүссэн.

Түүнчлэн энэхүү журмыг Парисын хэлэлцээрийн 6 дугаар зүйл, ялангуяа 2/СМА.3 “Парисын хэлэлцээрийн 6.2 дахь хэсэгт хамаарах хамтын ажиллагааны хандлагын удирдамж”, мөн 6/СМА.4 болон СМА.6 шийдвэрүүдэд туссан талуудын зөвшөөрөл олгох, сааруулалтын үр дүнг бүртгэх, мөшгих, бүртгэлийн систем хоорондын уялдаа холбоо, тайлагнал, харгалзах тохируулга хийхтэй холбоотой шаардлага, журмуудад нийцүүлэн боловсруулах бөгөөд олон улсын карбон зах зээлийн бүртгэл, тайлагналын тогтолцоотой уялдсан үндэсний карбон бүртгэлийн системийн эрх зүйн зохицуулалтыг бүрдүүлнэ.

2. **“Хүлэмжийн хийн ялгарлыг хэмжих, тайлагнах, баталгаажуулах журам”**-ыг хуулийн төслийн 7.1.8-д Засгийн газар батлахаар тусгасан. Парисын хэлэлцээрийн 13 дугаар зүйл болон 18/CMA.1 Парисын хэлэлцээрт оролцогч талуудын бага хурлын шийдвэрээр баталсан Enhanced Transparency Framework (ETF) буюу ил тод байдлын тогтолцоо нь улс орнууд хүлэмжийн хийн ялгарлын тооллого, үндэсний тодорхойлсон хувь нэмрийн зорилтын (NDC) хэрэгжилтийн ахиц, дасан зохицох арга хэмжээ болон санхүүжилтийн мэдээллийг нэгдсэн аргачлалаар хэмжих, тайлагнах, баталгаажуулах (MRV/MPGs) үүргийг хүлээлгэсэн. Монгол Улс олон улсын өмнө хүлээсэн тайлагналын үүргээ (BTR, NIR, Initial Report гэх мэт) хэрэгжүүлэхийн тулд мэдээллийн чанар, үнэн зөв байдал, харьцуулах боломжийг хангах үндэсний MRV тогтолцоог бий болгох шаардлагатай. Иймд олон улсын аргачлал, стандарт тогтмол шинэчлэгдэж буй нөхцөлд хэмжилт, тайлагнал, баталгаажуулалтын журмыг Засгийн газрын түвшинд баталж, шинэчлэн мөрдүүлэх эрх зүйн зохицуулалтыг бий болгох шаардлагатай байна.

Уг журмаар төрийн байгууллага, орон нутгийн байгууллага, төрийн болон хувийн хэвшлийн аж ахуйн нэгж, төсөл, хөтөлбөр хэрэгжүүлэгч этгээдээс хүлэмжийн хийн ялгарал, шингээлтийг хэмжих, тооцох, тайлагнах, баталгаажуулах үйл ажиллагааг нэгдсэн аргачлал, стандартын дагуу хэрэгжүүлэх харилцааг зохицуулна. Энэхүү журам нь хүлэмжийн хийн үндэсний тооллого боловсруулах, Үндэсний тодорхойлсон хувь нэмэр (ҮТХН)-ийн хэрэгжилтийн үр дүнг тооцох, олон улсын тайлан бэлтгэх, карбон зах зээлийн төсөл, ногоон санхүүжилтийн үр дүнг баталгаажуулах, байгууллагын түвшний ялгарлын мэдээллийг нэгтгэх, хянахад дагаж мөрдөнө.

Түүнчлэн уг журам нь Парисын хэлэлцээрийн 13 дугаар зүйлтэй холбоотой 18/CMA.1 “Ил тод байдлын сайжруулсан тогтолцооны аргачлал, журам, удирдамж (MPGs)” шийдвэр болон түүнд заасан хүлэмжийн хийн тооллого, Үндэсний тодорхойлсон хувь нэмрийн хэрэгжилтийн тайлагнал, хяналт (QC), чанарын баталгаажуулалтын (QA) шаардлагад нийцүүлэн боловсруулах бөгөөд мэдээллийн үнэн зөв, бүрэн бүтэн, ил тод, харьцуулах боломжтой байдлыг хангах зорилготой.

3. **“Ногоон болон уур амьсгалын санхүүжилтийн орлогын урсгалыг бүртгэх, тайлагнах, ил тод байдлыг хангах журам”**-ыг хуулийн төслийн 7.1.9-д Засгийн газар батлахаар тусгасан. Парисын хэлэлцээрийн 9–11 дүгээр зүйл, мөн ил тод байдлын тогтолцооны хүрээ болох 18/CMA.1, 19/CMA.1 Парисын хэлэлцээрт оролцогч талуудын бага хурлын шийдвэрүүд нь уур амьсгалын санхүүжилтийн эх үүсвэр, урсгал, дэмжлэгийн мэдээллийг тайлагнах, ил тод байдлыг хангах үүргийг улс орнуудад хүлээлгэсэн. Түүнчлэн олон улсын болон хувийн эх үүсвэрээс орж ирэх ногоон санхүүжилт, карбон зах зээлийн орлого, үр дүнд суурилсан төлбөрүүдийн зарцуулалт, давхар бүртгэл, ил тод байдал, үр ашигтай хяналтыг хангах шаардлага нэмэгдэж байна. Иймд ногоон болон уур амьсгалын санхүүжилтийн орлогын урсгалын бүртгэл, тайлагнал, ил тод байдлын журмыг баталж, үндэсний болон олон улсын тайлагналын шаардлагыг хангах, хөрөнгө оруулагчдын итгэлийг нэмэгдүүлэх хэрэгцээ үүссэн.

Уг журмаар төрийн байгууллага, орон нутгийн байгууллага, санхүүгийн байгууллага, төсөл, хөтөлбөр хэрэгжүүлэгч болон бусад холбогдох этгээдээс ногоон болон уур амьсгалын санхүүжилтийн эх үүсвэр, зарцуулалт, үр дүн, орлогын урсгалын мэдээллийг бүртгэх, тайлагнах, нэгтгэх, хянах, олон нийтэд ил тод мэдээлэх харилцааг зохицуулна.

Энэхүү журмыг улсын болон орон нутгийн төсөв, олон улсын уур амьсгалын сан, зээл, буцалтгүй тусламж, ногоон бонд, карбон зах зээл болон бусад эх үүсвэрээс бүрдсэн уур амьсгалын санхүүжилтийн урсгалыг давхардалгүй, үр ашигтай, ил тод байдлаар хянах, Үндэсний тодорхойлсон хувь нэмэр (ҮТХН)-ийн хэрэгжилтэд оруулж буй хувь нэмрийг үнэлэх, олон улсын тайлагналд ашиглана.

Уг журам нь Парисын хэлэлцээрийн 13 дугаар зүйл болон 18/CMA.1 “Ил тод байдлын сайжруулсан тогтолцооны аргачлал, журам, удирдамж (MPGs)” шийдвэрт туссан уур амьсгалын санхүүжилтийн тайлагнал, ил тод байдлын шаардлагад нийцүүлэн боловсруулагдах бөгөөд уур амьсгалын санхүүжилтийн мэдээллийн үнэн зөв, бүрэн бүтэн, харьцуулах боломжтой байдлыг хангах зорилготой.

4. **“Уур амьсгалын өөрчлөлтийн Үндэсний платформын үйл ажиллагааг удирдах журам”**-ыг хуулийн төслийн 7.1.10-д Засгийн газар батлахаар тусгасан. Уур амьсгалын өөрчлөлтийн асуудал нь олон салбар, олон оролцогчийн мэдээлэл, тайлагнал, зөвшөөрөл, бүртгэл, хяналт-шинжилгээ, үнэлгээ, санхүүжилтийн мэдээллийг нэгтгэн зохицуулах шаардлагатай байдаг. Парисын хэлэлцээрийн хүрээнд Үндэсний тодорхойлсон хувь нэмрийн зорилт, ил тод байдлын тогтолцоо, 6 дугаар зүйл, дасан зохицох арга хэмжээний тайлан зэрэг олон улсын тайлагналын тогтолцоо нь мэдээллийн уялдаа холбоо, нэгдсэн бүртгэлийн дэд бүтцийг шаардаж байгаа бөгөөд 5/CMA.1, 10/CMA.1 Парисын хэлэлцээрт оролцогч талуудын бага хурлын шийдвэр нь бүртгэлийн болон мэдээллийн системийн шаардлагыг тогтоосон. Иймд Үндэсний платформын үйл ажиллагааны журмыг баталж, мэдээлэл солилцох, бүртгэл хөтлөх, тайлагнах, хяналт тавих, холбогдох байгууллагуудын уялдаа холбоог хангах зохицуулалтыг бүрдүүлэх зорилготой.

6.2. Засгийн газрын тогтоолоор батлуулах 4 бодлого, стратегийг дараах байгууллагууд боловсруулна. Үүнд:

1. Үндэсний тодорхойлсон хувь нэмрийн зорилтод нийцүүлэн карбон зах зээлийн бодлого, стратеги – БОУАӨЯ;
2. Ногоон санхүүжилтийн стратеги - ЭЗХЯ, СЯ;
3. Үндэсний тодорхойлсон хувь нэмэр, Уур амьсгалын өөрчлөлтөд дасан зохицох үндэсний төлөвлөгөө - БОУАӨЯ;
4. Улс, орон нутгийн төсөв, төр, хувийн хэвшлийн түншлэлээр хэрэгжүүлэх ногоон төсөл, хөтөлбөрийг тодорхойлсон ногоон таксономи - ЭЗХЯ, СЯ.

6.3. Байгаль орчин, уур амьсгалын өөрчлөлтийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагын батлах 3 журам , 2 аргачлал:

1. **“Үндэсний тодорхойлсон хувь нэмрийн зорилтын хэрэгжилтийг хэмжих, тайлагнах, баталгаажуулах журам”**-ыг хуулийн төслийн 8.2.14-д Байгаль орчин, уур амьсгалын өөрчлөлтийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага батлахаар тусгасан. Уг журмаар төрийн байгууллага, орон нутгийн байгууллага, салбарын байгууллага болон бусад холбогдох этгээдээс Үндэсний тодорхойлсон хувь нэмэр (ҮТХН)-ийн зорилт, арга хэмжээний хэрэгжилтийн үр дүнг тооцох, мэдээлэл цуглуулах, нэгтгэх, тайлагнах, баталгаажуулах үйл ажиллагааг нэгдсэн аргачлал, зохион байгуулалтаар хэрэгжүүлэх харилцааг зохицуулна. Энэхүү журам нь хүлэмжийн хийн ялгарлыг бууруулах, шингээлтийг нэмэгдүүлэх, дасан зохицох арга хэмжээний үр дүн, ҮТХН-ийн зорилтын хэрэгжилтийн явцыг үнэлэх, үндэсний болон олон улсын тайлагнал боловсруулах, бодлого, төлөвлөлтийн шийдвэр гаргалтад ашиглах үндсэн хэрэгсэл болно.

Уг журмыг Парисын хэлэлцээрийн 4 дүгээр зүйл, 13 дугаар зүйл болон 18/CMA.1 “Ил тод байдлын сайжруулсан тогтолцооны аргачлал, журам, удирдамж (MPGs)” шийдвэрт туссан ҮТХН-ийн хэрэгжилтийн явцыг мөшгих, тайлагнах, мэдээллийн ил тод байдал, үнэн зөв, харьцуулах боломжтой байдлыг хангах шаардлагад нийцүүлэн боловсруулах бөгөөд ҮТХН-ийн хэрэгжилтийн үр дүнг олон улсын түвшинд тайлагнах эрх зүйн зохицуулалтыг бүрдүүлэх зорилготой.

2. **“Уур амьсгалын өөрчлөлтийн нөлөөлөл, эмзэг байдал, эрсдэлийн үнэлгээ хийх журам”**-ыг хуулийн төслийн 8.2.15-д Байгаль орчин, уур амьсгалын өөрчлөлтийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага батлахаар тусгасан. Журмаар уур амьсгалын өөрчлөлтийн өнөөгийн болон ирээдүйн нөлөөлөл, эмзэг байдал, эрсдэлийг үндэсний, салбарын, бүс нутгийн болон орон нутгийн түвшинд шинжлэх ухаанд суурилан үнэлэхтэй холбоотой үйл ажиллагаа, аргачлал, мэдээлэл цуглуулах, боловсруулах, тайлагнах харилцааг зохицуулна. Түүнчлэн уг журмыг Парисын хэлэлцээрийн 7 дугаар зүйл,

7/СМА.1 “Үндэсний дасан зохицох төлөвлөгөө болон дасан зохицох мэдээлэлтэй холбоотой удирдамж”, мөн 18/СМА.1 “Ил тод байдлын сайжруулсан тогтолцооны аргачлал, журам, удирдамж (MPGs)” шийдвэрт туссан дасан зохицох арга хэмжээ, нөлөөлөл, эмзэг байдал, эрсдэлийн үнэлгээ, тайлагналын шаардлагад нийцүүлэн боловсруулах бөгөөд уур амьсгалын эрсдэлийг хөгжлийн бодлого, төлөвлөлтөд нэгтгэх эрх зүйн зохицуулалтыг бүрдүүлнэ. Мөн үнэлгээний үр дүнг үндэсний болон орон нутгийн хөгжлийн бодлого, дасан зохицох төлөвлөгөө, хөрөнгө оруулалт, эрсдэлийн удирдлагад ашиглах боломжтой болно.

3. **“Итгэмжлэгдсэн, хараат бус этгээдийг бүртгэх журам”**-ыг хуулийн төслийн 26.4-т байгаль орчин, уур амьсгалын өөрчлөлтийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага батална гэж тусгасан. Уг журмаар хүлэмжийн хийн ялгарлын хэмжилт, тайлагнал, баталгаажуулалт, карбон зах зээл, ногоон болон уур амьсгалын санхүүжилтийн үр дүнг баталгаажуулах чиглэлээр үйл ажиллагаа эрхлэх итгэмжлэгдсэн, хараат бус этгээдийг бүртгэх, бүртгэлээс хасах, хяналт тавихтай холбоотой харилцааг зохицуулна. Энэхүү журам нь магадлан итгэмжлэгдсэн мэргэжлийн байгууллага, аудитын байгууллага, шинжээч болон бусад хараат бус этгээдийн мэргэжлийн чадавх, хараат бус байдал, ашиг сонирхлын зөрчилгүй байдлыг хангах, баталгаажуулалтын үйл ажиллагааны үнэн зөв, найдвартай байдлыг хамгаалах үндэс болно. Журмыг Парисын хэлэлцээрийн 13 дугаар зүйл болон 18/СМА.1 “Ил тод байдлын сайжруулсан тогтолцооны аргачлал, журам, удирдамж (MPGs)”, мөн Парисын хэлэлцээрийн 6 дугаар зүйлтэй холбоотой 2/СМА.3, 6/СМА.4 болон СМА.6 шийдвэрүүдэд туссан тайлагнал, баталгаажуулалт, техникийн шинжилгээ, бүртгэлийн тогтолцооны шаардлагад нийцүүлэн боловсруулах бөгөөд карбон зах зээл болон уур амьсгалын санхүүжилтийн ил тод, найдвартай тогтолцоог дэмжинэ.

4. **“Хүлэмжийн хийн үндэсний тооллого, хэтийн төсөөллийг боловсруулах аргачлал” болон “Хяналт, чанарын баталгаажуулалт хийх аргачлал”**-ыг хуулийн төслийн 13.5-д Байгаль орчин, уур амьсгалын өөрчлөлтийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага батлахаар тусгасан. Уг аргачлалаар хүлэмжийн хийн ялгарал, шингээлтийн үндэсний тооллого, салбарын болон үндэсний түвшний хэтийн төлөв, төсөөллийг боловсруулах, холбогдох өгөгдөл, мэдээллийг цуглуулах, боловсруулах, хянах, баталгаажуулах үйл ажиллагааг нэгдсэн аргачлалын дагуу хэрэгжүүлэх харилцааг уялдаатайгаар зохицуулна. Аргачлалыг төрийн байгууллага, орон нутгийн байгууллага, салбарын байгууллага, эрдэм шинжилгээ, судалгааны байгууллага болон бусад холбогдох этгээд хүлэмжийн хийн ялгарал, шингээлтийн мэдээллийг боловсруулах, Үндэсний тодорхойлсон хувь нэмэр (ҮТХН)-ийн хэрэгжилтийг үнэлэх, урт болон дунд хугацааны бодлого, төлөвлөлт боловсруулах, олон улсын тайлагнал бэлтгэх явцад ашиглана. Аргачлалыг Парисын хэлэлцээрийн 13 дугаар зүйл болон 18/СМА.1 “Ил тод байдлын сайжруулсан тогтолцооны аргачлал, журам, удирдамж (MPGs)” шийдвэрт туссан хүлэмжийн хийн үндэсний тооллого, тайлагнал, хяналт (QC), чанарын баталгаажуулалтын (QA) шаардлагад нийцүүлэн боловсруулах бөгөөд мэдээллийн үнэн зөв, бүрэн бүтэн, ил тод, харьцуулах боломжтой байдал, олон улсын техникийн шинжилгээний шаардлагыг хангасан байна.

5. **“Салбарын хүлэмжийн хийн ялгарлыг тооцох аргачлал”**-ыг хуулийн төслийн 8.3.3-д бусад төрийн захиргааны төв байгууллага Байгаль орчин, уур амьсгалын өөрчлөлтийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагатай хамтран батлахаар тусгасан. Эрчим хүч, аж үйлдвэр, хөдөө аж ахуй, газар ашиглалт, ой, хог хаягдал болон бусад салбарын хүлэмжийн хийн ялгарал, шингээлтийг тооцох, мэдээлэл цуглуулах, боловсруулах, тайлагнах үйл ажиллагааг нэгдсэн аргачлалын дагуу хэрэгжүүлэх харилцааг зохицуулна. Энэхүү аргачлал нь төрийн байгууллага, орон нутгийн байгууллага, салбарын байгууллага, аж ахуйн нэгж болон бусад холбогдох этгээдээс салбарын түвшний хүлэмжийн хийн ялгарлын мэдээллийг боловсруулах, хүлэмжийн хийн үндэсний тооллого гаргах, Үндэсний тодорхойлсон хувь нэмэр (ҮТХН)-ийн хэрэгжилтийг үнэлэх, бодлого, төлөвлөлт, олон улсын тайлагналд ашиглах үндсэн аргачлал болно. Түүнчлэн уг аргачлалыг Парисын хэлэлцээрийн 13 дугаар зүйл болон 18/СМА.1 “Ил тод байдлын сайжруулсан тогтолцооны аргачлал, журам, удирдамж (MPGs)” шийдвэрт туссан хүлэмжийн хийн тооллого,

тайлагналын шаардлагад нийцүүлэн боловсруулах бөгөөд IPCC-ийн удирдамж, аргачлалд үндэслэн салбаруудын ялгарлын мэдээллийн үнэн зөв, бүрэн бүтэн, ил тод, харьцуулах боломжтой байдлыг хангах зорилготой.

Дээр дурдсан журмууд нь Хууль тогтоомжийн тухай хуулийн 27¹ дүгээр зүйлд заасан захиргааны хэм хэмжээний актын шаардлагад нийцүүлэн боловсруулагдсан болно. Тодруулбал, эдгээр журам нь “Уур амьсгалын өөрчлөлтийн тухай” хуулийн тодорхой зүйл, хэсэг, заалтыг хэрэгжүүлэхэд чиглэсэн бөгөөд хуулийн зорилго, зарчим, зохицуулах харилцааны хүрээтэй уялдсан, түүнийг хэрэгжүүлэх аргачлал, үйл ажиллагааны нарийвчилсан зохицуулалтыг тогтоох зориулалттай.

Мөн тухайн журам тус бүрээр зохицуулах харилцааны зорилго, хамрах хүрээ, хэрэгжүүлэх субъект, эрх бүхий байгууллага, хэрэгжүүлэх арга хэлбэр, тайлагнал, хяналт, баталгаажуулалтын үндсэн шаардлагыг тодорхой тусгасан бөгөөд хуульд заасан бүрэн эрхийн хүрээнд Засгийн газар болон холбогдох төрийн захиргааны төв байгууллага батлахаар тусгасан.

Түүнчлэн эдгээр журам нь НҮБҮАӨСК, Парисын хэлэлцээр болон холбогдох Талуудын бага хурлаар батлагдсан олон улсын шийдвэрүүд, Ил тод байдлын сайжруулсан тогтолцоо (ETF)-ны аргачлал, журам, удирдамж (MPGs), олон улсад ашиглаж буй стандарт, аргачлалтай нийцүүлэн боловсруулахаар заасан ба үндэсний хууль тогтоомж болон Монгол Улсын олон улсын гэрээгээр хүлээсэн үүргийн хэрэгжилтийг хангуулах зорилготой.

Эдгээр журмаар иргэн, хуулийн этгээдийн хуульд заасан эрх, хууль ёсны ашиг сонирхлыг дордуулсан шинэ үүрэг, хязгаарлалт бий болгоогүй бөгөөд зөвхөн хуульд туссан зохицуулалтыг хэрэгжүүлэх, мэдээллийн ил тод байдал, тайлагнал, нэгдсэн зохион байгуулалт, хяналт, үнэн зөв байдлыг хангах зохицуулалтыг нарийвчлан тогтоож байгаагаараа онцлогтой. Иймд захиргааны хэм хэмжээний акт батлахад тавигдах хууль зүйн үндэслэл, шаардлагыг хангаж байна.

Долоо. Хуулийн төсөл нь Монгол Улсын Үндсэн хууль, Монгол Улсын олон улсын гэрээ болон бусад холбогдох хуультай хэрхэн уялдах, уг хуулийг хэрэгжүүлэхтэй холбогдон цаашид шинээр боловсруулах, нэмэлт, өөрчлөлт оруулах, хүчингүй болгох хуулийн талаар

Уур амьсгалын өөрчлөлтийн тухай хуулийн төслийг Монгол Улсын Үндсэн хууль, Монгол Улсын олон улсын гэрээ болон холбогдох бусад хууль тогтоомжид нийцүүлэн боловсруулсан болно.

Хуулийн төсөлтэй холбогдуулан Агаарын тухай, Авто замын тухай, Аж ахуйн нэгжийн орлогын албан татварын тухай, Барилгын тухай, Байгаль орчныг хамгаалах тухай, Гамшгаас хамгаалах тухай, Олон улсын гэрээний тухай, Статистикийн тухай, Тариалангийн тухай, Хот байгуулалтын тухай, Эрчим хүчний хэмнэлтийн тухай хуульд тус тус нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслүүд, Уур амьсгалын өөрчлөлтийн тухай хуулийг дагаж мөрдөх журмын тухай хуулийн төслийг тус тус боловсруулсан.

№	Хууль тогтоомж	Өөрчлөх зүйл заалт	Одоо байгаа заалт	Өөрчлөх болсон тайлбар
1.	Агаарын тухай хууль	1 дүгээр зүйл. Агаарын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1.1 дэх заалтын “уур амьсгалын өөрчлөлтийн талаарх” гэснийг хассугай.	6 дугаар зүйл.Засгийн газрын бүрэн эрх Хэвлэх 6.1.Засгийн газар хүрээлэн байгаа агаар /цаашид "агаар" гэх/ хамгаалах талаар дараах бүрэн эрхийг хэрэгжүүлнэ: 6.1.1.агаар хамгаалах, уур амьсгалын өөрчлөлтийн талаарх бодлого боловсруулах, холбогдох хөтөлбөрийг хэрэгжүүлэх;	Уур амьсгалын өөрчлөлтийн асуудлыг Агаарын тухай хуулийн зохицуулалтын хүрээнээс хасаж, давхардал, хийдэл, эрх зүйн зөрчил үүсэхээс сэргийлэх, хуулийн зохицуулалтын уялдаа холбоог хангах
		2 дугаар зүйл. Агаарын тухай тухай хуулийн 3 дугаар зүйлийн 3.1.21, 6 дугаар зүйлийн 6.1.2, 24 дүгээр зүйлийг тус тус хүчингүй болсонд тооцсугай.	3.1.21."хүлэмжийн хий" гэж хэт улаан туяаг шингээн авч буцаан туяаруулах шинж чанартай байгалийн буюу хүний үйл ажиллагааны гаралтай хийн мандлын бүрэлдэхүүн хэсгийг. 6.1.2.уур амьсгалын өөрчлөлтийн тухай Нэгдсэн Үндэстний Байгууллагын суурь конвенц /цаашид "Конвенц" гэх/-ийг хэрэгжүүлэх, уур амьсгалын өөрчлөлтөд дасан зохицох, экологийн эмзэг байдлыг болон уур амьсгалын өөрчлөлтийн сөрөг нөлөөллийг бууруулахтай холбогдсон арга хэмжээг улсын хэмжээнд зохион байгуулж, нэгдсэн удирдлагаар хангах үүрэг бүхий Уур амьсгалын үндэсний хороо байгуулах; 24 дүгээр зүйл.Уур амьсгалын өөрчлөлтөд дасан зохицох, түүний сөрөг нөлөөллийг бууруулах 24.2.Хүлэмжийн хийн ялгарал болон шингээлтийн улсын тооллогыг Конвенцийн талуудын бага хурлаар баталсан арга зүйн дагуу байгаль орчны асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага зохион байгуулж явуулна. 24.3.Аж ахуйн үйл ажиллагааны явцад хүлэмжийн хийг ихээр ялгаруулах эх	3.1.21-д заасан “хүлэмжийн хий”-ийн тодорхойлолт нь “Уур амьсгалын өөрчлөлтийн тухай” хуульд нэр томъёоны нэгдмэл, олон улсын хэрэглээтэй нийцсэн байдлаар дахин тодорхойлогдон тусгагдсан 6.1.2-т заасан Уур амьсгалын үндэсний хороо байгуулах, Конвенцын хэрэгжилтийг зохион байгуулахтай холбоотой зохицуулалт нь шинэ хуулиар үндэсний зохицуулагч байгууллага, техникийн болон мэргэжлийн зөвлөл, салбар дундын зохицуулалтын тогтолцоог илүү өргөн хүрээнд, нарийвчлан зохицуулсан тул уг зохицуулалтыг давхардуулан хадгалах шаардлагагүй

			үүсвэрээс ялгарах хүлэмжийн хийн зөвшөөрөгдөх дээд хэмжээг төрийн захиргааны төв байгууллага холбогдох бусад байгууллагатай хамтран батална.	
2.	Авто замын тухай хууль	1 дүгээр зүйл. Авто замын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.2 дахь хэсгийн “хөрөнгө оруулахыг” гэснийг “зам тээврийн салбарт хүлэмжийн хийн ялгарал багатай, уур амьсгалын өөрчлөлтөд тэсвэртэй технологи, инновац, үйлдвэрлэлийн аргыг нэвтрүүлэхийг” гэж нэмсүгэй.	6 дугаар зүйл. Авто зам, замын байгууламжийн санхүүжилт 6.2.Төр, хувийн хэвшлийн түншлэлийн хүрээнд дотоод, гадаадын хөрөнгө оруулагчид авто замын салбарын бүтээн байгуулалтад хөрөнгө оруулахыг төрөөс дэмжинэ.	Зам, тээврийн салбар нь хүлэмжийн хийн ялгарлын өсөн нэмэгдэж буй эх үүсвэрийн нэг бөгөөд уур амьсгалын өөрчлөлтийн нөлөөгөөр үер, хөрсний эвдрэл, цэвдэг хайлах зэрэг эрсдэл авто замын дэд бүтцэд сөргөөр нөлөөлөх болсон. Иймд авто замын бүтээн байгуулалт, хөрөнгө оруулалтыг уур амьсгалын өөрчлөлтийг сааруулах болон дасан зохицох бодлоготой уялдуулах шаардлага үүсээд байна. Энэ хүрээнд төр, хувийн хэвшлийн түншлэлийн хүрээнд дотоод, гадаадын хөрөнгө оруулагчдыг авто замын салбарт хүлэмжийн хийн ялгарал багатай, уур амьсгалын өөрчлөлтөд тэсвэртэй технологи, инновац, үйлдвэрлэлийн арга нэвтрүүлэхэд чиглэсэн хөрөнгө оруулалт хийхийг дэмжих эрх зүйн үндсийг бүрдүүлэх зорилгоор Авто замын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.2 дахь хэсэгт нэмэлт оруулахаар тусгасан. Хуулийн төслийн 20.7. “Уур амьсгалын хөрөнгө оруулалтад үзүүлэх урамшуулал, дэмжлэг нь хувийн хэвшлийн хөрөнгө оруулалтыг татах, эрсдэлийг бууруулах, урт хугацааны тогтвортой, уур амьсгалын өөрчлөлтөд дасан зохицсон хүлэмжийн хийн ялгарал багатай хөгжлийг дэмжихэд чиглэнэ” гэж заасныг мөн үндэслэсэн.
3.	Аж ахуйн нэгжийн орлогын албан татварын тухай хууль	1 дүгээр зүйл. Аж ахуйн нэгжийн орлогын албан татварын тухай хуулийн 22.5.3-ын “хаягдлыг багасгах,” гэсний дараа болон 22.9.1-ийн “цөлжилтийг сааруулах” гэсний дараа “хүлэмжийн хийн ялгарлыг бууруулах, шингээлтийг нэмэгдүүлэх” гэж тус тус нэмсүгэй.	22.5.3.байгалийн нөөцийг хэмнэлттэй ашиглах, орчны бохирдол, хаягдлыг багасгах, байгальд ээлтэй техник, тоног төхөөрөмжийг борлуулсан орлогод ногдох албан татварыг; 22.9.Албан татвар төлөгчийн орлого олох үйл ажиллагаатай хамааралгүй	Монгол Улс хүлэмжийн хийн ялгарлыг бууруулах, нүүрстөрөгчийн шингээлтийг нэмэгдүүлэх зорилтыг Үндэсний тодорхойлсон хувь нэмэр (ҮТХН)-т тусган хэрэгжүүлж байгаа бөгөөд хувийн хэвшлийн оролцоо, ногоон хөрөнгө оруулалтыг татварын бодлогоор дэмжих шаардлага үүсээд байна.

			доор дурдсан үйл ажиллагааг нийгмийн хариуцлагын хүрээнд дэмжих зорилгоор элэгдэл тооцох үндсэн хөрөнгөд оруулсан хөрөнгө оруулалт, харилцан хамааралгүй бусад этгээдэд олгосон санхүүгийн дэмжлэг, хандивын зардлыг энэ хуулийн 20.1-д заасны дагуу ногдуулсан албан татвараас хасаж хөнгөлнө. Хөнгөлөх дүн нь тухайн татварын жилийн татвар ногдох орлогын 1 хувь хүртэл хэмжээнээс хэтрэхгүй байна: 22.9.1.ой, амьтан, ус зэрэг байгалийн баялаг хамгаалах, нөөцийг нэмэгдүүлэх, зохистой ашиглах, нөхөн сэргээх, агаар, ус, хөрсний бохирдлыг бууруулах, цөлжилтийг сааруулах;	Иймд байгальд ээлтэй техник, тоног төхөөрөмжийн хэрэглээ, байгаль орчныг хамгаалах, цөлжилтийг сааруулахтай холбоотой татварын дэмжлэгийн зохицуулалтад хүлэмжийн хийн ялгарлыг бууруулах, шингээлтийг нэмэгдүүлэх үйл ажиллагааг хамруулах зорилгоор Аж ахуйн нэгжийн орлогын албан татварын тухай хуулийн 22.5.3 болон 22.9.1-д нэмэлт оруулахаар тусгасан. Энэхүү өөрчлөлтөөр аж ахуйн нэгжийн ногоон хөрөнгө оруулалт, уур амьсгалын өөрчлөлтийг сааруулах чиглэлээр хэрэгжүүлэх үйл ажиллагааг татварын бодлогоор дэмжих эрх зүйн үндэс бүрдэх ач холбогдолтой. Дээрх асуудлыг хуулийн төслийн 18.6, 20.7 дахь заалттай тус тус нийцүүлсэн болно.
4.	Барилгын тухай хууль	1 дүгээр зүйл.Барилгын тухай хуулийн 33 дугаар зүйлд доор дурдсан агуулгатай 33.1.26 дахь заалт нэмсүгэй: “33.1.26.барилга байгууламж, үйл ажиллагаанаас ялгарч болох хүлэмжийн хийн хэмжээг тогтоох;” 2 дугаар зүйл.Барилгын тухай хуулийн 33 дугаар зүйлийн “33.1.26” дахь заалтын дугаарыг “33.1.27” гэж өөрчилсүгэй.	33.1.26.хууль тогтоомжид заасан бусад эрх. 33.1.26.хууль тогтоомжид заасан бусад эрх.	Барилгын салбар нь эрчим хүчний хэрэглээ өндөртэй бөгөөд барилга байгууламж барих, ашиглахтай холбоотойгоор хүлэмжийн хийн ялгарал ихээр үүсдэг. Монгол Улс хүлэмжийн хийн ялгарлыг бууруулах зорилтыг хэрэгжүүлэх хүрээнд барилгын салбарын ялгарлыг тооцох, үнэлэх, бууруулах бодлого, арга хэмжээг үе шаттай хэрэгжүүлэх шаардлагатай тул уг салбараас ялгарах хүлэмжийн хийн хэмжээг тогтоох эрх зүйн үндсийг бүрдүүлэх зорилгоор Барилгын тухай хуулийн 33 дугаар зүйлд холбогдох бүрэн эрхийг нэмэхээр тусгасан. Энэхүү өөрчлөлтөөр барилгын салбарын хүлэмжийн хийн ялгарлыг үнэлэх, эрчим хүчний хэмнэлттэй, бага ялгаралтай барилгын технологи, стандартыг хөгжүүлэх, уур амьсгалын өөрчлөлтийг сааруулах бодлоготой уялдуулах нөхцөл бүрдэнэ.
5.	Байгаль орчныг хамгаалах тухай хууль	1 дүгээр зүйл. Байгаль орчныг хамгаалах тухай хуулийн 2 дугаар зүйлд дараах агуулга бүхий 2 дахь	2 дугаар зүйл.Байгаль орчныг хамгаалах тухай хууль тогтоомж	Уур амьсгалын өөрчлөлтийг сааруулах, дасан зохицох, даван туулах, хүлэмжийн хийн ялгарлыг бууруулах, шингээлтийг нэмэгдүүлэх, карбон зах

		хэсэг, 37 дугаар зүйлд дараах агуулга бүхий 9 дэх хэсэг тус тус нэмсүгэй: “2.2.Уур амьсгалын өөрчлөлтийг сааруулах, дасан зохицох, даван туулах, хүлэмжийн хийн ялгарлыг бууруулах, шингээлтийг нэмэгдүүлэх, карбон зах зээлийг хөгжүүлэхтэй холбогдсон харилцааг Уур амьсгалын өөрчлөлтийн тухай хуулиар зохицуулна. “37.9.Энэ хуулийн 35 дугаар зүйлийн 1 дэх хэсгийн 8-д заасан мэдээллийг Уур амьсгалын өөрчлөлтийн тухай хуульд заасан үндэсний зохицуулагч байгууллага болон аймаг, нийслэлийн Засаг дарга жил бүрийн 12 дугаар сарын 20-ны өдрийн дотор мэдээллийн нэгдсэн санд оруулсан байна.”	1.Байгаль орчныг хамгаалах тухай хууль тогтоомж нь Монгол Улсын Үндсэн хууль, энэ хууль болон тэдгээртэй нийцүүлэн гаргасан хууль тогтоомжийн бусад актаас бүрдэнэ. 2.Монгол Улсын олон улсын гэрээнд энэ хуульд зааснаас өөрөөр заасан бол олон улсын гэрээний заалтыг дагаж мөрдөнө. 37 дугаар зүйл.Мэдээллийн санд мэдээлэл төвлөрүүлэх үүрэг бүхий байгууллага, хэрэгжүүлэх хугацаа	зээлийг хөгжүүлэхтэй холбогдсон суурь харилцааг Уур амьсгалын өөрчлөлтийн тухай анхдагч хуулиар зохицуулах тул Байгаль орчныг хамгаалах тухай хуулийн зохицуулалтын хүрээнд хамаарахгүй болно. Байгаль орчныг хамгаалах тухай хуульд дээрх харилцааг “Уур амьсгалын өөрчлөлтийн тухай” хуулиар зохицуулахаар тусгайлан зааж, хууль тогтоомжийн уялдаа холбоо, зохицуулалтын давхардлыг арилгах зорилгоор 2 дугаар зүйлд нэмэлт оруулахаар тусгасан.
		2 дугаар зүйл.Байгаль орчныг хамгаалах тухай хуулийн 35 дугаар зүйлийн 1 дэх хэсгийн 8 дахь заалтын “уур амьсгал” гэснийг уур амьсгалын өөрчлөлтийн мэдээллийн нэгдсэн сан; гэж, 2 дугаар зүйлийн 2 дахь хэсгийг 3 дахь хэсэг гэж, 35 дугаар зүйлийн 2 дахь хэсгийн “1-7, 9-12” гэснийг “1-12” гэж, 3 дахь хэсгийн “9-12” гэснийг “8-12” гэж тус тус өөрчилсүгэй.	35 дугаар зүйл.Мэдээллийн сангийн бүрдэл Хэвлэх 1.Улсын мэдээллийн сан дараахь зүйлийн талаархи мэдээллээс бүрдэнэ: 1/газар, түүний хөрс; 2/газрын хэвлий, ашигт малтмал; 3/ус, рашаан; 4/ой; 5/байгалийн ургамал;	Уур амьсгалын өөрчлөлттэй холбоотой мэдээлэл, өгөгдлийг үндэсний хэмжээнд нэгдсэн мэдээллийн санд төвлөрүүлэх, тайлагнал, мэдээллийн ил тод байдлыг хангах зорилгоор Үндэсний зохицуулагч байгууллага болон аймаг, нийслэлийн Засаг дарга холбогдох мэдээллийг тогтоосон хугацаанд мэдээллийн нэгдсэн санд оруулах үүргийг тодорхой болгох шаардлага үүссэн тул хуулийн 35 дугаар зүйлийн 1 дэх хэсгийн 8-д заасан Уур амьсгалын мэдээллийг Үндэсний зохицуулагч байгууллага болон аймаг, нийслэлийн Засаг дарга жил бүрийн 12 дугаар сарын 20-ны өдрийн дотор мэдээллийн нэгдсэн санд оруулсан байна.” гэж өөрчилснөөр уур амьсгалын мэдээллийг байгаль орчны мэдээллийн нэгдсэн санд нэгтгэхээр өөрчилсөн болно.

			6/амьтан; 7/агаар, түүний бохирдол; 8/уур амьсгал;	Байгаль орчныг хамгаалах тухай хуулийн 35 дугаар зүйлийн 1 дэх хэсгийн 8 дахь заалтын “уур амьсгал” гэснийг “уур амьсгалын өөрчлөлтийн мэдээллийн нэгдсэн сан” гэж өөрчилснөөр Байгаль орчны мэдээллийн улсын сангийн нэг үндсэн бүрэлдэхүүн хэсэг болж өргөжих болно.
6.	Гамшгаас хамгаалах тухай хууль	1 дүгээр зүйл. Гамшгаас хамгаалах тухай хуулийн 7 дугаар зүйлийн 1 дэх хэсгийн “үнэлгээ хийнэ.” гэснийг “хийх бөгөөд уур амьсгалын өөрчлөлтийн нөлөөлөл, эмзэг байдал, эрсдэлийн үнэлгээний дүгнэлт, уур амьсгалын төсөөллийн мэдээллийг харгалзан үзнэ.” гэж өөрчилсүгэй.	7 дугаар зүйл. Гамшгийн эрсдэлийг үнэлэх 7.1. Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, төрийн болон нутгийн захиргааны байгууллага, хуулийн этгээд нь өмчийн хэлбэрийг үл харгалзан гамшгийн эрсдэлийн ерөнхий болон нарийвчилсан үнэлгээ хийнэ.	Уур амьсгалын өөрчлөлтийн нөлөөгөөр ган, зуд, үер, хүчтэй салхи, ой хээрийн түймэр зэрэг цаг агаарын гаралтай гамшигт үзэгдлийн давтамж, эрчим нэмэгдэж, гамшгийн эрсдэлийн шинж чанар өөрчлөгдөх хандлагатай байна. Иймд гамшгийн эрсдэлийн үнэлгээг зөвхөн өнөөгийн нөхцөл байдалд бус, уур амьсгалын өөрчлөлтийн ирээдүйн нөлөөлөл, эмзэг байдал, эрсдэлийн үнэлгээ болон уур амьсгалын төсөөллийн мэдээлэлд үндэслэн хийх шаардлага үүсээд байна. Энэ хүрээнд гамшгийн эрсдэлийн үнэлгээнд уур амьсгалын өөрчлөлтийн нөлөөлөл, эмзэг байдал, эрсдэлийн үнэлгээний дүгнэлт, уур амьсгалын төсөөллийн мэдээллийг харгалзан үзэх зохицуулалтыг тусгасан ба энэхүү өөрчлөлтөөр гамшгийн эрсдэлийн үнэлгээний чанар, урьдчилан сэргийлэх чадавх сайжирч, уур амьсгалын өөрчлөлтөд дасан зохицсон эрсдэлийн удирдлагын тогтолцоог хөгжүүлэх орчин бүрдэнэ.
7.	Олон улсын гэрээний тухай хууль	1 дүгээр зүйл. Олон улсын гэрээний тухай хуулийн 8 дугаар зүйлд доор дурдсан агуулгатай 8.3.3 дахь заалт нэмсүгэй: “8.3.3. Улсын Их Хурлаас соёрхон баталсан олон улсын гэрээний тодорхой заалтыг хэрэгжүүлэх зорилгоор байгуулж байгаа олон улсын гэрээ.”	8.3. Дараахь олон улсын гэрээг соёрхон батлах шаардлагагүй ба Засгийн газар байгуулж болно: 8.3.1. Гадаад улс, олон улсын байгууллага, гадаад улсын болон олон улсын банк, санхүүгийн байгууллагаас олгох тусламжийн хүрээнд гаалийн болон нэмэгдсэн өртгийн албан татвараас хөнгөлөх, чөлөөлөх зохицуулалт бүхий олон улсын гэрээ;	Монгол Улс Парисын хэлэлцээрийн хүрээнд уур амьсгалын өөрчлөлтийг сааруулах, дасан зохицох, карбон зах зээл, ногоон санхүүжилт, технологи дамжуулалттай холбоотой хамтын ажиллагааг өргөжүүлж байна. Энэ хүрээнд Парисын хэлэлцээрийн хэрэгжилтийг хангах зорилгоор техникийн болон хэрэгжилтийн шинжтэй нэмэлт гэрээ, хэлэлцээр, хамтын ажиллагааны баримт бичиг байгуулах шаардлага нэмэгдэж байна. Гэвч Улсын Их Хурлаар соёрхон баталсан олон улсын гэрээний тодорхой заалтыг хэрэгжүүлэх зорилгоор байгуулах олон улсын гэрээний эрх

			8.3.2.Иргэд харилцан зорчих визийн нөхцөл, хураамжаас хөнгөлөх, чөлөөлөх зохицуулалт бүхий олон улсын гэрээ.	зүйн зохицуулалт Олон улсын гэрээний тухай хуульд тодорхой тусгагдаагүй байна. Иймд Улсын Их Хурлаас соёрхон баталсан олон улсын гэрээний хэрэгжилтийг хангах хүрээнд байгуулах хэрэгжилтийн шинжтэй олон улсын гэрээг Засгийн газар байгуулах эрх зүйн үндсийг тодорхой болгох зорилгоор Олон улсын гэрээний тухай хуулийн 8 дугаар зүйлд нэмэлт оруулахаар тусгасан. Энэхүү өөрчлөлтөөр Парисын хэлэлцээрийн 6 дугаар зүйлтэй холбоотой карбон зах зээлийн хамтын ажиллагааны Засгийн газар хоорондын хэрэгжилтийн шинжтэй олон улсын гэрээг шуурхай байгуулах, олон улсын хамтын ажиллагааны уян хатан, үр ашигтай механизмыг бүрдүүлэх боломжтой болно. Тухайлбал, Швейцарь, Сингапур, БНСУ-тай байгуулсан Парисын хэлэлцээрийг хэрэгжүүлэх тухай хоёр улсын засгийн газар хоорондын хамтын ажиллагааны хэлэлцээрийг дурдаж болно.
8.	Статистикийн тухай хууль	1 дүгээр зүйл.Статистикийн тухай хуулийн 6.1.5-д “е.хүлэмжийн хийн ялгарлын бууруулалт, шингээлтийн үр дүн” гэсэн заалт нэмсүгэй.	6 дугаар зүйл.Албан ёсны статистикийн мэдээллийн үзүүлэлт, түүнийг гаргах үндэслэл 1.Албан ёсны статистикийн мэдээлэлд дараахь үндсэн үзүүлэлт хамаарна: 5/ хүрээлэн байгаа орчны статистикийн үзүүлэлт: а/ газрын хөрсний хамгаалалт, эвдрэл; б/ цэвэр усны нөөц, ус ашиглалт, бохирдолт, цэвэрлэгээ, хаягдал; в/ агаарын бохирдол;	Монгол Улс Парисын хэлэлцээрийн хүрээнд хүлэмжийн хийн ялгарлыг бууруулах, шингээлтийг нэмэгдүүлэх зорилтыг хэрэгжүүлж байгаа бөгөөд Үндэсний тодорхойлсон хувь нэмрийн хэрэгжилтийн үр дүнг хэмжих, тайлагнах, үнэлэхэд статистикийн нэгдсэн мэдээллийн тогтолцоо чухал ач холбогдолтой байна. Гэвч Статистикийн тухай хуульд хүрээлэн буй орчны статистикийн үзүүлэлтэд хүлэмжийн хийн ялгарлын бууруулалт, шингээлтийн үр дүнтэй холбоотой үзүүлэлт тусгагдаагүй тул уур амьсгалын өөрчлөлтийн бодлого, тайлагналын хэрэгцээг бүрэн хангаж чадахгүй байна. Иймд хүлэмжийн хийн ялгарлыг бууруулах, шингээлтийг нэмэгдүүлэхтэй холбоотой мэдээллийг албан ёсны статистикийн тогтолцоонд хамруулах, үндэсний болон олон улсын тайлагнал, бодлого төлөвлөлтийн үндсэн мэдээллийн суурийг бүрдүүлэх зорилгоор

			г/ ойн хамгаалалт, нөхөн сэргээлт; д/ дархан цаазтай амьтны тоо, агнуур.	Статистикийн тухай хуулийн 6.1.5-д “хүлэмжийн хийн ялгарлын бууруулалт, шингээлтийн үр дүн” гэсэн үзүүлэлт нэмэхээр тусгасан. Энэхүү өөрчлөлтөөр уур амьсгалын өөрчлөлтийн талаарх статистикийн мэдээллийн чанар, хүртээмж, харьцуулах боломж сайжирч, ҮТХН болон олон улсын тайлагналын хэрэгжилтийг дэмжих суурь бүрдэнэ.
9.	Тариалангийн тухай хууль	1 дүгээр зүйл. Тариалангийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.2.1 дэх заалтын “тохиромжгүй болсон” гэсний дараа “уур амьсгалын өөрчлөлтөд сөргөөр нөлөөлсөн” гэж, 19 дүгээр зүйлийн 19.7 дахь хэсгийн “эргэлтэд оруулах” гэсний дараа “газар тариалангийн салбарт нүүрстөрөгч багатай, уур амьсгалын өөрчлөлтөд тэсвэртэй технологи, инновац, үйлдвэрлэлийн аргыг нэвтрүүлэх” гэж тус тус нэмсүгэй.	14 дүгээр зүйл. Тариалангийн газрын зориулалт өөрчлөх Хэвлэх 14.1.Тариалангийн газрын зориулалтыг өөрчлөхгүйгээр өөр бусад зориулалтаар эзэмших, ашиглахыг хориглоно. 14.2.Дараахь тохиолдолд тариалангийн газрын зориулалтыг өөрчилж болно: 14.2.1.тариалангийн газрын хөрсний үржил шим алдагдсан, элэгдэлд орсон, давсажсан, намагшсаны улмаас тариалангийн үйлдвэрлэлд тохиромжгүй болсон нь энэ хуулийн 26.2-т заасан шинжилгээгээр тогтоогдсон; 19 дүгээр зүйл. Төрөөс тариалангийн үйлдвэрлэлийг дэмжих, санхүүжүүлэх 19.7.Энэ хуулийн 14.2.1-д заасан газрыг тариалангийн эргэлтэд оруулах зорилгоор хөрсний үржил шимийг сайжруулах арга хэмжээ авсан бол төрөөс дэмжлэг үзүүлж болно.	Уур амьсгалын өөрчлөлтийн нөлөөгөөр ган, хөрсний доройтол, чийгийн дутагдал, цөлжилт зэрэг эрсдэл нэмэгдэж, тариалангийн газрын үржил шим, ашиглалтад сөрөг нөлөө үзүүлж байна. Иймд тариалангийн газрын зориулалт өөрчлөх үндэслэлд уур амьсгалын өөрчлөлтийн сөрөг нөлөөллийг харгалзан үзэх шаардлага үүсээд байна. Тодруулбал, “уур амьсгалын өөрчлөлтөд сөргөөр нөлөөлсөн” нөхцөл нь тухайн газрыг тариалангийн зориулалтад тохиромжгүй болсон гэж үзэх, цаашид ашиглалтыг хязгаарлах үндэслэл болох тул Тариалангийн тухай хуулийн 14.2.1-д тусгахаар боловсруулсан. Мөн тариалангийн газрын хөрсний үржил шимийг сэргээх, эргэлтэд оруулах төрийн дэмжлэгийг нүүрстөрөгч багатай, уур амьсгалын өөрчлөлтөд тэсвэртэй технологи, инновац, үйлдвэрлэлийн арга нэвтрүүлэхтэй уялдуулах зорилгоор 19.7-д нэмэлт оруулахаар тусгасан. Энэхүү өөрчлөлтөөр газар тариалангийн салбарын дасан зохицох чадавхыг бэхжүүлэх, хөрсний доройтлыг бууруулах, тогтвортой үйлдвэрлэлийг дэмжинэ.

10.	Хот байгуулалтын тухай хууль	1 дүгээр зүйл. Хот байгуулалтын тухай хуулийн 7 дугаар зүйлийн 7.1.1 дэх заалтын “хэрэгжүүлж” гэсний дараа “уур амьсгалын өөрчлөлт,” гэж нэмсүгэй.	7 дугаар зүйл. Хот байгуулалтын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагын бүрэн эрх 7.1. Хот байгуулалтын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага хот байгуулалтын талаар дараахь бүрэн эрхийг хэрэгжүүлнэ: 7.1.1. хот байгуулалтын төрийн бодлогыг хэрэгжүүлж, хүн амын нутагшилт, суурьшлын хөгжлийн ерөнхий төсөл, бүсийн хөгжлийн төсөл, чөлөөт бүс, хот, тосгоны хөгжлийн ерөнхий төлөвлөгөөний харилцан уялдааг зохицуулж, хэрэгжилтэд хяналт тавих;	Уур амьсгалын өөрчлөлтийн нөлөөгөөр үер, хэт халалт, усны хомсдол, агаарын бохирдол, дэд бүтцийн эрсдэл зэрэг хот суурин газрын тулгамдсан асуудал нэмэгдэж байна. Иймд хот байгуулалт, нутаг дэвсгэрийн төлөвлөлтийг уур амьсгалын өөрчлөлтийн нөлөөлөл, эрсдэлтэй уялдуулан хэрэгжүүлэх шаардлагатай. Хот байгуулалтын бодлого, хүн амын нутагшилт, суурьшлын хөгжлийн төлөвлөлтөд уур амьсгалын өөрчлөлтийн асуудлыг тусган хэрэгжүүлэх эрх зүйн үндсийг тодорхой болгох зорилгоор Хот байгуулалтын тухай хуулийн 7 дугаар зүйлийн 7.1.1-д нэмэлт оруулахаар тусгасан. Энэхүү өөрчлөлтөөр хот төлөвлөлт, дэд бүтцийн хөгжлийг уур амьсгалын өөрчлөлтийг сааруулах болон дасан зохицох бодлоготой уялдуулах, уур амьсгалд тэсвэртэй, тогтвортой хот байгуулалтыг хөгжүүлэх нөхцөл бүрдэнэ.
11.	Эрчим хүчний хэмнэлтийн тухай хууль	1 дүгээр зүйл. Эрчим хүчний хэмнэлтийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1.1 дэх заалтын “үндэсний хөтөлбөрийг” гэснийг “Үндэсний тодорхойлсон хувь нэмрийн зорилтод заасан арга хэмжээг” гэж өөрчилсүгэй.	6 дугаар зүйл. Төрийн захиргааны төв байгууллагын бүрэн эрх 6.1. Төрийн захиргааны төв байгууллага эрчим хүч хэмнэх, үр ашгийг дээшлүүлэх чиглэлээр дараах бүрэн эрхийг хэрэгжүүлнэ: 6.1.1. эрчим хүч хэмнэлтийн талаарх төрийн бодлого, хууль тогтоомж, үндэсний хөтөлбөрийг хэрэгжүүлэх ажлыг зохион байгуулж, биелэлтийг хангуулах;	Эрчим хүчний салбар нь Монгол Улсын хүлэмжийн хийн ялгарлын гол эх үүсвэрийн нэг бөгөөд эрчим хүчний хэмнэлт, үр ашгийг нэмэгдүүлэх нь Үндэсний тодорхойлсон хувь нэмэр (ҮТХН)-ийн зорилтыг хэрэгжүүлэх үндсэн арга хэмжээний нэг юм. Иймд эрчим хүч хэмнэх, үр ашгийг дээшлүүлэх бодлого, арга хэмжээг Үндэсний тодорхойлсон хувь нэмрийн зорилттой уялдуулан хэрэгжүүлэх эрх зүйн үндсийг тодорхой болгох зорилгоор Эрчим хүчний хэмнэлтийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1.1-д өөрчлөлт оруулахаар тусгасан. Энэхүү өөрчлөлтөөр эрчим хүчний хэмнэлтийн бодлого нь уур амьсгалын өөрчлөлтийг сааруулах үндэсний зорилттой нэгдсэн байдлаар хэрэгжих нөхцөл бүрдэх юм.
12.	Уур амьсгалын өөрчлөлтийн тухай хуулийг дагаж мөрдөх журмын тухай	1 дүгээр зүйл. Карбон зах зээлийг зохицуулах, карбон кредитийг бүртгэх журмыг Уур амьсгалын өөрчлөлтийн тухай батлагдсан хууль хүчин төгөлдөр болсон		Уур амьсгалын өөрчлөлтийн тухай хуулийн төсөлд заасан журмуудыг олон улсад дагаж мөрдөж байгаа журам, аргачлалуудад нийцүүлэн, үндэсний онцлогийг харгалзан боловсруулж батлуулах шаардлагатай.

		өдрөөс хойш 1 жилийн дотор Засгийн газар батална. 2 дугаар зүйл. Хүлэмжийн хийн ялгарлыг хэмжих, тайлагнах, баталгаажуулах журмыг Уур амьсгалын өөрчлөлтийн тухай батлагдсан хууль хүчин төгөлдөр болсон өдрөөс хойш 1 жилийн дотор батална. 3 дугаар зүйл. Ногоон болон уур амьсгалын санхүүжилтийн орлогын урсгалыг бүртгэх, тайлагнах, ил тод байдлыг хангах журмыг Уур амьсгалын өөрчлөлтийн тухай батлагдсан хууль хүчин төгөлдөр болсон өдрөөс хойш 1 жил 6 сарын дотор батална. 4 дүгээр зүйл. Уур амьсгалын өөрчлөлтийн Үндэсний платформын үйл ажиллагааг удирдах журмыг Уур амьсгалын өөрчлөлтийн тухай батлагдсан хууль хүчин төгөлдөр болсон өдрөөс хойш 1 жил 6 сарын дотор батална. 5 дугаар зүйл. Энэхүү хуулийг Уур амьсгалын өөрчлөлтийн тухай хууль хүчин төгөлдөр болсон өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.		Журмуудыг боловсруулах, батлуулах үйл ажиллагааг гүйцэтгэхдээ олон тооны журам, зааврыг нарийвчлан судалж, шийдвэрлэх шаардлагатай байгаа тул 1-1,5 жилийн хугацааг тогтоосон болно.
--	--	--	--	---